



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ



European Union

B+HR
BUSINESS AND HUMAN RIGHTS | ASIA



UN
DP

БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ ХӨТӨЛБӨР



МОНГОЛ УЛС ДАХЬ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

2020-4-29



EUROCHAMBER MONGOLIA
ЕВРОП МОНГОЛЫН ХАМТАРСАН ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ



ХААН БАНК



MDSKhanLex




Terra
express

МОНОС
ГРҮПП



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- | | |
|---------------|--|
| ГХЯ | Гадаад Харилцааны Яам |
| ЕХ | Европын Холбоо |
| МУХАҮТ | Монголын үндэсний Худалаа
Аж Үйлдвэрийн Танхим |
| НУБ | Нэгдсэн Үндэстний Байгууллага |
| НУБХХ | Нэгдсэн Үндэстний
Байгууллагын Хөгжлийн
Хөтөлбөр |
| ХЭҮК | Хүний Эрхийн Үндэсний Комисс |



Нээлтийн үг	5
Панел Хэлэлцүүлэг: Хүний эрхийн асуудал яагаад бизнест хамааралтай вэ?	21
Танилцуулга: Хүний эрхийн менежментийн арга хэрэгсэл, мэдлэгийн бүтээгдэхүүнүүд	44
Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний гарын авлага: Таван толгойн бүлэг ордын жишээ	47
Хүний Эрхийн Хянан Магадлага: Ковид-19 цар тахлын үед бизнесийн байгууллага өөрийгөө үнэлэх түргэвчилсэн тест	51
Панел хэлэлцүүлэг: Бизнес ба Хүний Эрх: Онолоос Практикт	55
Асуулт хариулт	74
Хаалтын үг	77



БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ ХӨТӨЛБӨР

МОНГОЛ УЛС ДАХЬ ЦАХИМ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ

2021 оны 4-р сарын 29

Арга хэмжээг дэмжигч байгууллагууд:



CAUX ROUND TABLE

ХААН БАНК

MDSKhanLex

Terra

МОНОС

Хурал зохион байгуулагч:

Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт зочид та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. “Бизнес ба хүний эрх: Хамгаалах, хүндлэх ба хамгаалах сэргээх механизмаар дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмжих нь” сэдэвт Азийн бүсийн хөтөлбөрийн Монгол улс дахь нээлтийн арга хэмжээнд цаг гарган оролцож байгаа та бүхэнд баярлалаа.

Энэхүү хөтөлбөрийг Европын Холбоо (ЕХ) -ны санхүүгийн дэмжлэгээр Монгол улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) болон Монгол Улсын Гадаад харилцааны яам (ГХЯ)-тай хамтран “Бизнес ба хүний эрх” Азийн бүсийн хөтөлбөр болон НҮБХХ-ийн Бангкок дахь бүсийн төвийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа билээ. Өнөөдрийн энэхүү арга хэмжээ 3 цаг үргэлжлэх ба салбарын манлайлагчид болон мэргэжилтнүүдээс бүрдсэн 2 панел хэлэлцүүлэг өрнөхийн зэрэгцээ бизнесийн байгууллагуудад зориулсан хүний эрх менежментийн арга хэрэгсэл болон мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг танилцуулна.

Хурал зохион байгуулагч:

Ингээд өнөөдрийн арга хэмжээг нээж үг хэлнэ үү хэмээн ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр таныг урьж байна.



Н.АНХБАЯР

ГХЯ-ны
Төрийн нарийн
бичгийн дарга

НЭЭЛТИЙН ҮГ

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

НҮБ-ийн Суурин төлөөлөгч хатагтай Илейн Конкиевич ЕХ-ноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн Газрын дэд Тэргүүн ноён Марко Ферри, мөн НҮБХХ-ийн Ази номхон далайн бүсийн хөтөлбөрийн удирдагч ноён Ливио Сарандреа болон бусад оролцож байгаа Эрхэм Хүндэт Төлөөлөгчид өө.

Манай Засгийн газар НҮБХХ болон ЕХ-ноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газартай хамтран зохион байгуулж байгаа НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, “Бизнес ба хүний эрх” төслийн нээлтийн үйл ажиллагааны урилгыг хүлээн авч энэ арга хэмжээнд оролцож байгаа та бүхэнд талархаж байгаагаа үүгээр илэрхийлье.

Манай улс 2015 онд хүний эрхийн төлөв байдлын илтгэлийн хоёр дахь тайланг хэлэлцүүлсэн. Энэ үеэр 150 зөвлөмж өгсний нэг бол Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх, энэ зорилгоор үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах зөвлөмжийг хүний эрхийн зөвлөмжийн оролцогч бусад орнуудаас өгсөн. Энэ зөвлөмжийг гурав дахь удаагаа буюу 2020 оны 11-р сард тайлан хэлэлцүүлэх үеэр өгсөн байдаг. Уг зөвлөмжүүдийг Монгол улс авч хэрэгжүүлнэ гэдгээ олон улсын байгууллагуудын өмнө амласан.

Энэ нь манай улс НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн зарчмыг хэрэгжүүлэх эрмэлзэл маш өндөр байгааг нотолж байгаа хэрэг гэж бодож байна. “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” баримт бичигт бизнесийн үйл ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үр нөлөөтэй механизм бий болгох чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг маш тодорхой болгож, нийгэмд бизнесийн байгууллагууд шударга ёс, хөгжил дэвшлээр шийдвэрлэх үүрэгтэй оролцох шаардлагатай байна. Монгол Улсад энэ ойлголт харьцангуй шинэ хэдий ч энэ ойлголтын зарчмыг дотоодын орчин нөхцөлд тулгарч буй сорилт бэрхшээлийг шийдвэрлэхтэй уялдуулан хэрэгжүүлэх нь чухал юм.

Ялангуяа өнөөдөр бидний өмнө тулгараад байгаа цар тахлын сорилтыг даван туулахад хүний эрхийг цөм болгосон төр, бизнесийн байгууллага, иргэний нийгмийн үр дүнтэй хамтын ажиллагаа, хамтын ажиллагааны хэм хэмжээ нэн шаардлагатай болох нь тодорхой байна.

Улс орны хөгжлийн үзэл баримтлал арга замыг тодорхойлж, чиглүүлэн зохицуулах гол институц нь төр хэдий боловч өдгөө энэ уламжлалт хандлага улам хувьсан шинэчлэгдэж, засаглал, үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд нийгмийн бүх талууд буюу иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог хангахыг чухалчлах болж байна.

Монгол Улс хөгжлийн бодлогодоо энэ арга хандлагыг хүний хөгжлийг хангах сайн засаглалын суурь арга зүй болгон дэвшүүлж байна. Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг боловсруулах үйл явц нь үүний нэгэн тод жишээ гэж бид үзэж байна. Энэхүү үйл явц “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг хийгээд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхойлсон хүний эрхийг бүрэн хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх олон талт түншлэлийг хөгжүүлэх, хүний эрхийн стандартыг нэвтрүүлэх, мөн төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргах зорилт, хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, хүний эрхийг хүндэтгэсэн бизнесийн соёлыг төлөвшүүлэхэд бодит түлхэц болно гэж үзэж байна.

Монгол улсад 2050 он гэхэд нийгмийн бүх харилцаанд хүний эрхийг бүрэн хангасан тогтолцоог төлөвшүүлэх зорилтыг хангахад эхний үе шат буюу 2030 он хүртэлх хүний эрхийн зарчимд суурилсан хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх, төр иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоог төлөвшүүлэх нь шийдвэрлэх үе юм. Та бүхэн анзаарсан бол Улсын их хурлаас саяхан хүний эрхийг хамгаалагчдын хуулийг эцэслэн баталсан ба одоо уг хуулийн хэрэгжилтийг хангах шаардлага тулгарч байна.

Иймд “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө” боловсруулан гаргахад энд хуран цугласан та бүгдийн бүх талын оролцоо чухал болохыг онцлон тэмдэглэж байна. Энэ нь цаашдаа хүний эрхийг хангах олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх, бусад улстай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд бидэнд нэн ач холбогдолтой үйл явц болох юм. Монгол Улсын засгийн газар өнгөрсөн хугацаанд бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг боловсруулах бодитой ажлуудыг хийсэн. ГХЯ-ны Сайдын 2019 оны 4-р сард гарсан А\38 тоот тушаалаар миний бие ахлан энэ төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан ба энэ ажлын хэсэгт холбогдох бүх яам, агентлаг бизнесийн төлөөлөл, ТББ, мэргэжлийн холбоод, их дээд сургуулиуд болон төрийн өмчит үйлдвэрийн газрууд зэрэг өргөн хүрээтэй төлөөлөл орж ажиллаж байгаа.

Төлөвлөгөө боловсруулах үйл явцыг 2019 оны 5-р сард албан ёсоор эхлүүлж, үндэсний зөвлөлдөх уулзалт, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах, төрийн байгууллагуудын албан хаагчдын дунд ойлголт, мэдлэгийг түгээх, шаардлагатай зарим эх сурвалжуудыг Монгол хэл рүү хөрвүүлэх зэрэг арга хэмжээг авсан. Эдгээр ажлыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Комиссарын дээд алба дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаад бид талархаж байна. Манай яамнаас үндэсний төлөвлөгөө боловсруулахад арга зүйн туслалцаа зайлшгүй шаардлагатай хэмээн үзэж НҮБХХ, ЕХ зэрэг түншлэгч байгууллагад хүсэлт тавьж идэвхтэй хамтран ажилласан. Үүний үр дүнд НҮБХХ-өөс Ази номхон далайн бүс нутагт ЕХ-ны дэмжлэгтэйгээр 2017-2020 онд хэрэгжүүлж буй бүс нутгийн түншлэлийг хэрэгжүүлэх замаар хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих буюу Бизнес ба Хүний эрх хөтөлбөрт 2021 оны 2 дугаар сараас эхлэн Монгол Улс хамрагдаж эхэлсэн. Гурван жилийн хугацаанд хэрэгжих энэхүү төслийн үйл ажиллагааг өнөөдөр албан ёсоор нээж байгаад ГХЯ-ны зүгээс туйлын талархалтай хүлээн авч байна. Энэ завшааныг ашиглан манай яам Засгийн газрын хүчин чармайлтыг дэмжиж, “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө” боловсруулахад дэмжлэг үзүүлж байгаа түншлэгч байгууллага болох НҮБХХ, ЕХ-нд гүн талархал илэрхийлж байна. Монгол Улс ЕХ-той 2017 оноос эхлэн жил бүр хүний эрхийн диалогийг хийж байгаа нь хоёр талын харилцааны үнэт зүйлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааны чухал механизм гэж бид үздэг. Өнөөдөр эхлүүлж байгаа энэ төсөл нь яриа хэлэлцээрийн бодит үр дүнгийн илрэл гэж бид үнэлж байна. Өнөөдрийн хэлэлцүүлэг арга хэмжээ нь бизнес ба хүний эрхийн зарчмын талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх, талуудын харилцан итгэлцлийг бэхжүүлэх, бизнес дэх хүний эрхийн чиглэлээр тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох шийдэл дэвшүүлэх зорилгод чухал хувь нэмэр оруулна гэж итгэж байна.

Та бүхний хэлэлцүүлэгт өндөр амжилт хүсье. Баярлалаа.



НАШИДА САТТАР

НУБХХ-ийн Орлогч,
Суурин төлөөлөгч

Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Европын холбооны дэд ерөнхийлөгч ноён Ферри, хатагтай ноёд оо!

НУБХХ нь Бизнес хүний эрхийн хөтөлбөр буюу энэ чухал хөтөлбөрийг Монгол улсад Ази тивд албан ёсоор хэрэгжүүлж байгаа 7 улсын нэг болгон Европын Холбооны санхүүжилтээр, НУБХХ-өөс хэрэгжүүлэхээр эхлүүлж байгаадаа туйлын их баяртай байна. Хүний эрх бол бүх нийтийг хамруулсан үндсэн чухал арга хэмжээ билээ. Хүний эрхийн түгээмэл тунхаг нь 1948 онд эх цэнхэр гариг маань дэлхийн хоёр том дайны сүйрэлд өртсөн, дайны дараах үнс нурман дээр бий болж зарлагдсан бөгөөд улс үндэстнүүдийг сэргээн босгох үйлсийн төлөө, хүний түгээмэл эрхийг хамгаалахад бид бүхэн хамтдаа бат суурьтай зогсох ёстой гэсэн ойлголттойгоор нэгдсэн юм.

Өнөөдөр ч бид гамшигтай нүүр тулаад байгаа нь КОВИД- 19 цар тахал бөгөөд уг тахал бидний эрхийг зөрчиж байгааг бид бүхэн мэдэж байгаа билээ. Тиймээс эрхээ хамгаалахын төлөө бүх хүч чадлаа зориулах болсны дотор бизнесийн талбарт ялангуяа их чухал болоод байна.

НУБ-ын Бизнес, хүний эрхийн удирдах зарчмууд нь 2011 онд батлагдсан бөгөөд засгийн газрууд, бизнесийн байгууллагуудад шаардлагатай байсан удирдамжаар хангаж, тэдний бизнесийн үйл ажиллагаа нь хүний эрхийг хэрхэн зөрчиж байгаад анхаарч, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зорилготой бий болсон юм. Монгол улс Үндэснийхээ үйл ажиллагааны төлөвлөгөөг ГХЯ-ны удирдлага санаачилгаар 2018 онд эхлүүлээд байна.

Монгол Улс энэхүү үнэ цэнэтэй түншлэл, хамтын ажиллагааны сүлжээнд НҮБХХ-тэй хамтран ажиллахаар нэгдэн орж, бид бүхэн буюу Европын Холбоо, МУГХЯ, Бизнес ба Хүний эрхийн Азийн хөтөлбөр, улсын ба олон улсын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах болж байгаадаа туйлын их баяртай байна.

Бизнес хүний эрхийн асуудал Монгол улсад маш чухал асуудал болоод байгаа билээ. Оролцогч талуудын хүчин чадлыг сайжруулах, асуудал бэрхшээлийг илрүүлэх, мэдлэг нэмэгдүүлэх, сурталчлах ажлуудыг чиглүүлэн ажиллахдаа бүлгийн гишүүд, бизнесийн төлөөлөгчид, олон нийтийг анхаарч ажиллах нь хөтөлбөрийн гол зорилго юм.

Сурталчилгаа, бодлого боловсруулалт, техникийн зөвлөмжийн дэмжлэг, чадавх бэхжүүлэх, танин мэдүүлэх ажиллагааг нэмэгдүүлэх, шинэчлэлийн платформ бий болгох, нэг нэгнээсээ суралцах, өөртөө туслах хамтын ажиллагаагаар дамжуулан бүсийн түвшинд дэмжин ажиллана.

Цаашлаад НҮБХХ нь ГХЯ-ыг хүний эрхийн хувьд тулгамдаж байгаа асуудлуудыг илрүүлж, тус улсыг үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь техникийн зөвлөмж дэмжлэг үзүүлэх буюу Бизнес хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

Хөтөлбөрөөр дамжуулан иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан жижиг үндэслэлүүдийг бий болгох, мөн тус улсын эмзэг бүлэгт бизнесийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар судалгаа хийх зэргээр хүний эрхийг хамгаалагчидтай хамтран ажиллана.

Уг хөтөлбөр нь бизнесийн үйл ажиллагаанаас болж хүний эрхээ зөрчүүлсэн хохирогчдын хохирлыг барагдуулах шүүхийн ба шүүхийн бус арга ажиллагааг илүү өргөн хүрээнд хүртэх боломж, хэрэгцээ шаардлагуудыг чиглэн ажиллах юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бизнесийн байгууллагуудад ашиг тус өгөөд зогсохгүй, эдийн засагт үр өгөөжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ сайн засаглал, аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг хангахад хүчтэй дэмжлэг үзүүлэх болно гэдгийг онцлох нь зүйтэй болов уу.

Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд салбаруудын нягт хамтын ажиллагаа, бүтээлч түншлэл чухал үүрэг гүйцэтгэх тул Хүний эрхийн үндэсний комисс, хүний эрхийг хамгаалагчид, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгчид, ТББ-ууд, бизнесийн түншүүд, МҮХАҮТ гээд бүх хамтрагч байгууллагууд уг ажиллагаанд идэвхтэй оролцож байгаад маш их баяртай байна. Монгол Улс дахь НҮБХХ-өөс бүх түншүүдтэйгээ хамтран ажиллаж, НҮБ-ын Бизнес, хүний эрхийн удирдах зарчмуудыг Монгол улсад амжилттайгаар нутагшуулан хэрэгжүүлэх баталгааг ханган ажиллах гэж байгаадаа туйлын баяртай байна. Монгол улсаа илүү амжилттай хөгжүүлэн ажиллахад бид бүгд асар их үүрэг гүйцэтгэх бөгөөд уг нэр төртэй үйл хэрэгт тууштай хамтран ажиллаж байгаа та бүхэнд баярлалаа.



МАРКО ФЕРРИ

Европын Холбооноос
Монгол Улсад суугаа
Төлөөлөгчийн газрын
дэд тэргүүн

Бүгдэд нь өдрийн мэнд!

Та бүхэнд маш их баярлалаа. Төрийн нарийн бичгийн дарга, хамтран ажиллагсад, та бүхэн намайг нээлтийн ажиллагаанд үг хэлнэ үү урьсанд баярлалаа. Миний бие уг төслийг анх үүсгэн эхлүүлсэн цаг үеэс хойш төслийн хүрээнд ажилласаар ирсэн учраас хувийн зүгээс маш их таатай байна. Европын Холбооны үндсэн суурь зарчмуудын хувьд бид хүний эрхийг хүчтэйгээр хамгаалагчид юм. Ази тивтэй холбоотой ганц хоёр үгээр яриагаа эхлэх нь зүйтэй байх.

Сүүлийн хэдэн арван жилд Ази тивийн хувьд эдийн засгийн өсөлт маш хүчтэй, динамик, хурдацтай өсөлттэй гэсэн тодотголоор тодорхойлогдож байгаа ч энэ өсөлт нь өөрийн гэсэн үр дагавар, сөрөг нөлөөнөөс ангид байсангүй. Азийн олон улс орны хувьд ундны ус бохирдсон, ой модыг эрчимтэй устган сүйтгэж, агаарын бохирдол асар их нэмэгдсэн гээд байгаль орчин улам бүр эрсдэлд өртөн доройтож байна. Зарим тохиолдолд барилга байгууламж, дэд бүтцийн томоохон төслүүд байгаль орчныг доройтуулж, нүүлгэн шилжүүлэхэд хүргээд байна.

Хөдөлмөрийн үйл ажиллагаа ихээр шаардсан үйлдвэрлэл нь ажлын орчныг асар ихээр эрсдэлд оруулж, ажилчдын эрхийг зөрчсөн, хүний эрүүл ахуйд асар хохиролтой, аюултай нөхцөл байдлыг бий болгодог. Ийм орчин нөхцөлд улс орнуудын засгийн газрын удирдах ажилтнуудын зүгээс НҮБ-ын удирдамж, зарчмуудыг эдгээр байгууллага, бизнесийн аваргуудын үйл ажиллагааг хүний эрхийг зөрчихгүй, зөрчигдөх эрсдэлийг бууруулах байдлаар явуулах удирдамжаар хангаж, бодлогын зохицуулалтаар оролцох хүрээ хязгаарыг тогтоох боломж гэж харах нь улам нэмэгдэх болсон байна.

ЕХ-ны тухай ярихад ЕХ нь өөрсдийнхөө буюу Европын компаниудыг бизнесийн үйл ажиллагааны хүчирхийллээс урьдчилан сэргийлэх баталгааг хангахад оролцох оролцоог сайжруулах, иймэрхүү тохиолдлууд харамсалтайгаар гарахад хариу арга хэмжээ авах боломжийг нэмэгдүүлэх байдлаар дэлхий даяарх бизнес эрхлэлтэд НҮБ-ын удирдамж, зарчмуудын хэрэгжүүлэлтийг сайжруулахад ихээхэн сонирхон дэмжсээр ирсэн.

НҮБ-ын удирдамжийг амжилттай хэрэгжүүлэхэд яамд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн хамтын ажиллагааны санал санаачилгыг шаарддаг. Ийм олон байгууллага, оролцогч талуудын хамтын ажиллагааг татан оролцуулах баталгаагаар хангахын тулд улс орны засгийн газруудыг үндэснийхээ үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргахыг нь удаа дараагийн үйл ажиллагаагаар уриалан сануулсаар байна.

Тиймээс ЕХ, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл улс орнуудыг НҮБ-ын удирдамж, зарчмуудыг өөрсдийн нутаг дэвсгэрт хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлсон үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахыг удаа дараа уриалсаар байна.

Миний гурав дахь буюу эцэст нь хэлэх зүйл маань Монгол Улсын тухайд юм. Монгол Улс Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан дараагийн улс байгаасай гэж хүсч, найдаж байна. Уг төлөвлөгөөгөө боловсруулахад нь ЕХ-ны зүгээс туршлагаасаа хуваалцахад бэлэн байгаа төдийгүй төслийг санхүүжүүлснээрээ уг үйл явцад хувь нэмрээ оруулж байгаа гэж бодож байна. Мөн ийнхүү тусалж байгаадаа ч маш их баяртай байна. Зарим тохиолдолд КОВИД-19 цар тахлын хямрал нь хэрэгжүүлэхээр зэхэж буй хөтөлбөрийн ач холбогдол, яаралтай байдлыг тодорхой харуулсан бөгөөд мөн хямрал нь хүний эрхийн шинэ зөрчил үүсгээд байгаа нь бизнес эрхлэгчид, тэдгээрт ажиллагчдад улам их дарамт учруулж байна. Үүний зэрэгцээ бизнесийн байгууллагууд хариуцлагатай ажиллаж, хүний эрх, түүний дотор хөдөлмөрийн эрх, аюулгүй эрүүл хөдөлмөрийн нөхцөлийг бүрдүүлэн үйл ажиллагаагаа явуулахад нийлүүлэлтийн сүлжээ илүү тэсвэртэй болохыг ч харуулаад байна.

Хүний эрхийн зөрчлийг арилгах, үнийн тогтвортой сүлжээг бий болгох зэрэг нь ЕХ-ны тэргүүлэх чиглэл хэвээр байх бөгөөд бид өнөөдөр энд оролцож байгаа Монголын бүх оролцогч талуудтай хамтран ажиллах болсондоо маш их баяртай байна. Үүгээр би яриагаа өндөрлөхийг хүсч байна. Бүх оролцогчдооо талархал илэрхийлэхийн ялдамд төсөл маань маш их үр дүнтэй, өндөр бүтээмжтэй байгаасай гэж ерөөж байна. Та бүхэнд маш их баярлалаа.

НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим ба Азийн бүсийн хөтөлбөрийн танилцуулгыг хийх хүндэт зочин илтгэгч Бизнес ба хүний эрхийн Ази номхон далайн удирдагч Ливио Сарандреа таныг урьж байна.

НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Удирдах Зарчим ба Азийн Бүсийн Хөтөлбөр

ЗОЧИН ИЛТГЭГЧ



ЛИВИО САРАНДРЕА

НҮБ-ын Хөгжлийн
Хөтөлбөрийн Бизнес
ба Хүний Эрхийн
Ази Номхон Далайн
Хөтөлбөрийн
Удирдагч

Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, хамтран ажиллагч Р.Ариунаа, хатагтай В.Оюу болон бусад оролцогчиддоо энэ өдрийн мэндийг хүргэе!

Жил гаруйхны өмнө бид цөөхүүлээ цуглаараад Монгол Улсыг үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хувилбарыг (нооргийг) гаргахад нь дэмжин ажиллах боломжтой байгаагаа ярилцаж байсан. Гэтэл жил гаруйхны хугацаанд хөтөлбөрөө эхлүүлэх боломжтой болсондоо туйлын их баяртай байна. Тиймээс ЕХ уг үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллах болсонд маш их баярлаж байна. Та бүхнийг намайг урьж энэ сайхан ажилд оролцуулж байгаад мөн баярлалаа. Өөрт оногдсон 15 минутаа ашиглахын тулд эхний слайдаа та бүхэндээ толилуулъя.

Өнөөдөр та бүхний туулж яваа зүйлсийн тухайд яриа өрнүүлэхэд та бүхний өмнө газрын зураг байгааг харж байгаа байх. Энэ нь одоо Монгол улсад явагдаж байгаа үйл ажиллагааг илүү өргөн хүрээний буюу Ази тивийн нөхцөл байдалд харахад маань туслах юм. Уг газрын зураг дээр улс орнуудын нэрэн дээр цэгүүдийг тэмдэглэсэн. Эдгээр цэг нь энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа улсуудыг харуулж байгаа юм. Эдгээр бүх улсууд нь ЕХ-ны болоод бусад хандивлагчдын санхүүжилтээр НҮБХХ-өөс хөтөлбөр хэрэгжүүлж буй улсууд болно.

Одоо та нарт харуулж байгаа энэ зураг маань нэлээн урам өгөхөөр зураг боловч дөрвөн жилийн өмнө энэ газрын зураг дээр нэг ч цэг харагдахгүй байх байсан.



НҮБ-ын Бизнес, хүний эрхийн удирдамж, зарчмууд нь бизнесийн стандарт болж, хүний эрхтэй тохирон нийцсэн болохыг бид сонслоо. Эдгээр стандартыг 10 жилийн өмнөөс өөрийн болгон авч хэрэгжүүлж эхэлсэн билээ. Энэ зургадугаар сард бид 10 жилийнхээ ойг тэмдэглэх гэж байна. Миний туршлагаас харахад 2016 оноос өмнө Азийн хувьд хүний эрх гэдэг зүйлийг хэн ч ингэж нухацтай авч үздэггүй байлаа. Тэгэхээр бизнес, хүний эрхийн тухайд сүүлийн 4-5 жилийн хугацаанд ахиц гарч байна. Энэ нь хэд хэдэн шалтгааны улмаас бий болсныг би дараагийнхаа слайд дээр үзүүлэх болно.

Тэгэхээр миний харж байгаагаар Азид хариуцлагатай бизнесийн тухай яриа хэлэлцээ эхлэсэнд нөлөөлөх таван хүчин зүйл байна. Та бүхний олонх нь энэ талаар мэдэж байгаа байх гэж бодож байна. Корпорацийн нийгмийн хариуцлага нь бизнесийн хариуцлагын тухай ойлголтоос давж гарсан бусдын сайн сайхны төлөө шинж чанартай зүйл юм. Энэ нь хүний эрхийг хамгаалах, түүнийг хөхиүлэн дэмжих үүрэг хариуцлага бөгөөд үүнийг өөрсдийн үйл ажиллагаа, нийлүүлэлтийн сүлжээнийхээ хэсэг нэг бүртээ уялдуулах тухай юм. Тэгэхээр Азид хариуцлагатай бизнесийн яриа хэлэлцээ эхлэсэн энэ өөрчлөлт хэрхэн бий болов гэдэг таван шалтгааныг дурдая.

Нэгдүгээрт хүн ардыг хүний эрхийн талаар сургаж, тэднийг хүний эрхийн төлөө явдаг, бизнесийн салбаруудыг хариуцлагатай байлгаж, нэмэлт үүрэг хариуцлага хүлээгчид болгох, төрийн үйл ажиллагаанд нэмэр хандив болгох сургалтуудаар дамжуулан тогтвортой бизнесийн үйл хэрэг, тэднийг биелүүлэх стандартын хэрэгцээ байгааг мэдэх мэдлэгт сургаж, мэдлэг өссөн шалтгаан байна.

Тэгэхээр эдгээрийн ихэнх нь мэдлэг нэмэгдүүлснээс болсон байна. Тиймд хариуцлагын тухай мэдлэг нь нэмэгдсэн байна. Түүнчлэн бизнест хүний эрхийг хүндлэн дээдлэх журмыг хүлээн авснаар аль аль талдаа хожил ирсэн бөгөөд бизнес хүний эрхийн төлөө явснаар бидний газрын зураг дээр харсанчлан бизнесийн яриа хэлэлцээр хурдацтай өргөжин тэлж байна.

Хоёрдугаарт улс орнууд нэг нэгнээсээ суралцаж, эрүүл өрсөлдөөнийг дундаа бий болгосон.

2016 оноос хойш зарим улс орнууд аль хэдийн урагш ахисан байгааг харж байна. Бизнес, хүний эрхийн тухайд Тайланд улс бүсдээ тэргүүлж, үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөгөө анхлан ноороглон гаргаж, нийлүүлэлтийн сүлжээгээ цэвэр ногоон өнгөтэй (зураг) болгосныг онцлох нь зүйтэй. Ази тивд энэ тухай яриа хэлэлцээр өссөн нь бизнесийн кейс тус бүртээ байгаа гэж бодож байна. Энэ тал дээр дахин эргэж ярина. Гэсэн хэдий ч засгийн газрууд өөрсдийн дэмжигчидийнхээ төлөө нэр хүндтэй байж, хамтрагч түншүүддээ хэлэх худалдааны үзэл бодлын сонирхлын тухайд ЕХ-ныхтой адил худалдааны бодлогуудад суурилсан үнэ цэнтэй, хувийн хэвшлүүд нь хүний эрхийг зөрчих эрсдэлгүй хөрөнгө оруулалттай тийм улс орнууд байж чадсан учраас гэж бодож байна. Тиймээс түрүүлж гараад бусдыгаа бизнесийн бодлогодоо хариуцлагатай байхад уриалан дагуулсан улсууд байна. Ийм улсуудын хувьд Тайланд тэргүүлж, Индонез удаалж, араас нь Малайз, Энэтхэг дагалдсан байна. Одоогийн байдлаар хэд хэдэн улс орнууд Тайландын жишгээр орж байгаагийн дотор Монгол улс явж байна.

Гуравдугаарт нийгмийн сүлжээгээр дамжуулан нэг нэгэндээ үзүүлж харуулах компаниуд ажлууд гэж бодож байна.

Өнөө үед бид өдөр бүр сонин, сэтгүүлээ дэлгээд бизнесийн үүрэг хариуцлагаа сайн биелүүлсэн эсвэл хөсөрдүүлж байгаа компаниудын тухай өгүүллийг унших боломжгүй нь тодорхой. Нийгэмд мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр дамжуулан бизнесийн үйл ажиллагаагаараа хүний эрхэд хор хохирол учруулсан, эсвэл сайн үр дагавар авчирсан тухай мэдээллийг маш ихээр үзэж сонсдог болсон учраас энэ тухай олон нийтийн мэдлэг тэлж байна. Дэлхийн хэмжээнд оршин тогтнодог, хүний эрхийг тэргүүлдэг томоохон корпорацуудын нэгийн жишээг би үргэлж дурьддаг ч өнөөдөр ямар корпорац гэдгийг нь дурьдахгүй. Хүмүүс надад намайг гамшигтай нэг зургийн төдий ойр байна гэж дандаа хэлдэг. Нүүр номон дээрх манай компанийн ганц зураг улсын нэр хүндтэй холбоотой олон саяын төлөөсийг манай компанид шаардах эрсдэлд хүргэнэ гэдэг. Дахин хэлэхэд бид ийм дэлхий ертөнцөд амьдарч байна. Мэдээллийн хэрэгслээр бизнес, хүний эрхийн талаар ярьсан зүйлс нь бизнес хүний эрхийн тухайд маш их өөрчлөлтийг авчирдаг гэдгийг компаниуд мөн ухаарч ойлгох болсон байна.

Дөрөвдүгээрт хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын зүгээс тавьж буй шаардлага, үзүүлж буй шахалт өссөнтэй холбоотой.

Энэ нь миний түрүүн хэлсэн зүйлтэй холбогдож байна. Тухайн бүтээгдэхүүнийг худалдан авснаар хүн ардын эрхэд ямар нөлөө үзүүлж байгааг хэрэглэгчид мэдэхийг хүсдэг болжээ. Миний гар утас ямар нэг тодорхой төрлийн хүчирхийлэл, зөрчилтэй холбогдож байна уу, гэж сонирхдог болсон байна. Тиймээс хэрэглэгчид, мөн хөрөнгө оруулагчид ч компаниудад тавих шаардлага нэмэгдсэн.

Тавдугаарт өнөөдрийн бидний яриа хэлэлцээртэй мэдээж маш ихээр холбогдох тэр зүйл нь худалдааны түншлэгчдээс шаардах болсон шинээр гарч ирж байгаа шаардлагууд юм.

ЕХ-оог худалдаа, үнийн хувьд тэргүүлж байгааг аль хэдийн дурьдсан билээ. ЕХ хүний эрхийг үргэлж өөрсдийнхөө худалдааны бодлогын нэг хэсэг байлгасаар ирсэн. Улс орон засгийн газрууд нийлүүлэлтийн сүлжээгээ цэвэр, ногоон болгож, бизнест хүний эрхийн бодлогыг нэвтрүүлэх нь давуу эрх болохыг ойлгож ухаараад байна. ЕХ-той түншилсэн худалдаа эрхлэлт хэмжээгээ давуулдаг нь тодорхой гэж хэлэх нь зүйтэй. Үнэнийг хэлэхэд энэ зүйл миний газрын зураг дээр харуулсан улсуудыг илүү түргэвчлүүлсэн гэж хэлж болно.

Дараагийн слайд дээр би ахицын дөрвөн баримтыг заан харуулж байна. Монгол улс үндэснийхээ үйл ажиллагааны төлөвлөгөөг ноороглон гаргаж байгаа учраас нэг нь Монгол гэдэг нь тодорхой байна.

Ахиц дэвшлийн нэгдүгээр баримт бол миний түрүүн хэлснээр засгийн газрууд үндэснийхээ бодлогын төлөвлөлтөд хувь нэмэр оруулахаар зэхэж байгаа нь яалтгүй ахиц дэвшил мөн. Ази тивд хоёр чухал газрын зургийг өөриймсүүлэн аваад байгаа нь Тайланд, Япон болон бусад олон улсууд буюу дор хаяж 5 улс НҮБХХ-тэй хамтран төлөвлөлтийн анхны зураглалаа гаргаж байгаа ахицтай үйл явц байна. Хариуцлагатай бизнесийн бодлогыг бий болгоход техникийн бодлогууд гарч байна.

Ахиц дэвшлийн хоёр дахь баримт нь бүс нутгийн түншлэлийн өсөлт мөн. 2016 оноос хойш НҮБХХ нь Ази Номхон далайн бүс нутгийн Бизнес-хүний эрхийн чуулга уулзалтыг зохион явуулдаг болоод байна. Уг чуулга уулзалтыг зохион байгуулсан 2016 оны анхны жил 120 оролцогч оролцсон. Сүүлийнх нь өнгөрсөн жил зохион байгуулагдсан бөгөөд үүнд 6000 хүн оролцсон юм. Уг арга хэмжээнд оролцсон оролцогч талууд болох бизнесийн байгууллагаас засаг төрийн удирдлагууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд энэ бүх тооны хүмүүс бүгд асуудлыг мэддэг болсон бөгөөд яриа хэлэлцээрт оролцох хүсэлтэй байгаа нь асар хурдацтай өсөн нэмэгдсэн байна. Тэд бараг бүгдээрээ дэлхийд бизнес ба хүний эрхийн сайн мэдээ тараагчид болсон учраас энэ бүхэн маш их үр дүнтэйгээр тархаж байна.

БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ ХӨТӨЛБӨР

Бизнесийн байгууллагууд хаана ч ямар ч хэлбэрээр үйл ажиллагаа явуулсан хүний эрхэд ЭЕРЭГ БА СӨРӨГ нөлөө үзүүлдэг.

ЭЕРЭГ



Ажлын байр



Дэд бүтэц




Хөгжил


СӨРӨГ



Хүүхдийн хөдөлмөр



Байгаль орчны
бохирдол



Авилгал, хээл
хахууль

НҮБ-аас 2011 онд хүний эрхийн талаар баримтлах засгийн газар болон компаниудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон “БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХИЙН УДИРДАХ ЗАРЧИМ”-ыг гаргасан.

Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим.pdf

Гурав дахь баримт нотолгоо нь сүүлийн жилүүдэд компаниуд хүний эрхийг хэрхэн хэрэгжүүлэх, хэрхэн ойлгох талаарх хүсэлтээ ихээр тавьдаг болсон байна. НҮБХХ-өөс компаниудад шаардлагуудыг хүргүүлж байгаа бөгөөд тэдгээр компаниуд одоо хэрхэн ажиллахаа ойлгодог болсон байна. Тиймээс НҮБХХ шиг байгууллагууд сургалтуудыг явуулж байгаа бөгөөд компаниуд техникийн хувьд хүний эрхийг дээдэлсэн байдлаар үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангуулах зорилготой. Тэдгээр хүсэлтүүд нь сараас сард өсөн нэмэгдэж байна.

Дөрөв дэх нотолгоо нь нөхөн сэргээлтийн кейсүүдийн тоо нэмэгдсэн явдал юм. Нөхөн сэргээлт гэдгээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр хүчирхийлэл гүнзгий хэмжээнд явагдсаны дараа компаниуд нөхөн сэргээх нөхөн төлбөрөөр хангадаг. Эсвэл үнэндээ зарим компаниуд зөрчил үүсгэснийхээ төлөө тодорхой улсын хууль эрхийн хүрээнд хуулийн хариуцлага хүлээх хэмжээнд очсон байдаг.

Энэ хүртэл би та бүхэнд дандаа эерэг, гоё талуудыг ярилаа. Судалгаа маш их байна. Гэсэн ч НҮБ-ын удирдамж, зарчмыг Азид танилцуулж, хэрэгжүүлнэ гэдэг урт хугацааны үйл явц байсан гэдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Өнөөдөр би та бүхэнд эсэргүүцэл, бэрхшээл байсныг мөн хэлэх нь зүйтэй. Тиймээс бидний өмнө ямар бэрхшээлүүд байна гэдгийг дараах гурваар илэрхийлье.

Нэгдүгээрт хэдийгээр бодлогын түвшинд ахиц дэвшил гарч байгаа, илүү олон компаниуд НҮБ-ын Удирдах Зарчмыг хүлээн авч байгаа ч бүс нутгуудын хувьд хүний эрхийг хамгаалагчдыг дарамтлах, амь насыг нь эрсдүүлэх явдал улам ихсэж байна. Энэ талаар анхаарах ёстой болоод байгаа нь нэлээн санаа зовоосон асуудал болж байна. Энэ завшааныг ашиглаад би Монгол Улсын хувьд хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалсан тодорхой хуулиудыг бий болгож байгаад нь баяр хүргэмээр байна. Өнөөдөр би үүнийг мэдэж авлаа. Энэ амжилтанд тань та нарт томоос том баяр хүргэе. Хүний эрхийн эдгээр эрхүүд нь хүний эрхийг хамгаалагчидтай хүчтэй холбоотой. Хүний эрхийг хамгаалагчид нь маш чухал оролцогчид учраас энэ үйл явцад бид тэднийг хамгаалах шаардлагатай. Харамсалтай нь Ази тивийн хувьд бүх газар ийм биш байна.

Миний хэлэх хоёр дахь бэрхшээл нь хэдийгээр бид газрын зураг дээр илүү олон цэгүүдийг харж байгаа ч гэсэн Азийн зарим хэсэгт харамсалтай нь бизнес, хүний эрхийн тухай яриа хэлэлцээр "ТЭГ" хэмжээнд, аль эсвэл маш хязгаарлагдмал байна. Тиймээс бид бизнес, хүний эрхийг дэлхий дахины үйл хэрэг болгож, Азид бүх газар нутагт энэ зарчмуудыг хүлээн авдаг болохыг хүсч байна. Миний нэр нь дурьдахгүй байгаа улс орнууд эдгээр нэр нь гарч байгаа улсуудынх шиг амжилт, ахиц гаргахгүй байгаа нь тодорхой байна.

Гурав дахь бэрхшээл нь Ковидтой холбоотойгоор мэдээ өсч, буурч байна

Зарим үед бид үүнийг зогсонги байдалд орох нь гэж түгшиж байсан боловч тэгсэнгүй. Харин ч бидний бодсоноос илүү цааш үргэлжилсэн. Гэсэн хэдий ч цар тахлын хямралаас болоод арай удааширсныг бид хүлээн зөвшөөрч байна. Мөн үнэндээ зарим улс орнууд өөр асуудлуудыг хуульчлан чухалчилж байна. Түрүүнд би НҮБ Удирдах Зарчмыг бий болгосны 10 жилийн ойгоо зургадугаар сард тэмдэглэх гэж байна гэж хэлсэн. НҮБ-ын ажлын хэсгийнхэн эдгээр хүний эрх дээр ажиллаж байгаа нь НҮБ-ын удирдах зарчмуудын хариуцагч бөгөөд НҮБХХ нь дараагийн арван жилийн газрын зураглал дээр ажиллаж байна.

Бизнес ба хүний эрх нь ирэх арван жилд ямаршуухан харагдах б хандлагыг би тодорхойлоод байна.

1 Бизнес хүний эрхийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөгөө гаргах улс орнуудын тоо хэмжээ өснө. Одоогийн байдлаар улс орнуудын хувьд янз бүр, өөр өөр байна. Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөн дээрээ ажиллаж байгаа нь ажиллахгүй байгаагаасаа илүү байна. Хамтрагч орнуудтайгаа адил түвшинд явж, тэдэнтэй эн зэрэгцэхийг хүсвэл улс орнууд ийм төлөвлөгөө гаргах ёстойгоо хүлээн зөвшөөрч, илүү олон тооны улсууд төлөвлөгөөгөө гаргаж газрын зураг дээрх тоо хэмжээ өснө гэж найдаж байна.

2 Дараагийн арван жилд гарч ирэх дараагийн хандлага нь асуудлыг танин мэдэхээс нийгмийн хөдөлгөөнд шилжих байх гэж найдаж байна. Хүн ард үүнийг мэдэхээс гадна эрхийг хүндлэх хэмжээнд хүрэхийг харахыг хүсч байна. Дараагийн арван жилд НҮБХХ үүнд хөрөнгө оруулж ажиллана.

3 Нэг хувьслыг харж байгаа нь хүний эрх, байгаль орчны талууд илүү холбогдсон байна. Энэ нь ЕХ үнэндээ хариуцлагатай бизнесийн эдгээр хоёр талыг нэгтгэн холбож байгаагийн үр дүн байна. ЕХ-оос Европын компаниудын тухайд байгаль орчин, хүний эрхийн заавал биелүүлэх шаардлагыг зарлан тунхагласан бодлогыг гаргасан. Тиймээс тэдгээр шаардлагуудыг ЕХ-д танилцуулж эхлэхэд тэдгээрийг Европ даяар нийлүүлэлтийн сүлжээндээ хэрэгжүүлэх шаардлага гарна. Байгаль орчин, хүний эрхийн тухай зайлшгүй хэм хэмжээ, шаардлагуудыг энэ жилд Европд батлан, хэрэгжүүлж эхэлснээр дэлхийн бусад улс орнуудад хүрч, Ази тивийн хувьд нийлүүлэлтэд олон талаар маш чухал ач холбогдолтой байх нь тодорхой.

4 Бизнес, хүний эрхийн үйл ажиллагааны цар хүрээ өсч байгаа нь үнэндээ тогтворжилтын асуудал, энх тайвны асуудалтай илүүтэй холбогдох болжээ. Хамгийн сүүлийн үеийн жишээ болох Мьянмар улсын жишээ бидэнд бизнес, хүний эрхийн тогтвортой байдал, энх тайвантай хэр нягт холбогдож байгааг харуулж байна. Бид ирэх арван жил энэ холбоосууд хэрхэн илүү холбогдохыг харах болно.

5 Ази тивийн хувьд бизнес-хүний эрхийн тухай яриа хэлэлцээ нь бараг тэр чигээрээ үндэстэн дамнасан компаниудын тухай байснаас илүүтэй ЖДҮ, албан бус салбаруудыг хамруулсан хэмжээнд хүрнэ гэж бодож байна. Энэ бол зайлшгүй хийх ёстой маш чухал алхам юм. Мэдээж амаргүй ч өнгөрсөн жилээс аль хэдийн өсөн нэмэгдэж байгааг нь харж байна.

6 Сүүлийн чухал зүйл маань худалдаа ба хөрөнгө оруулалт юм. Бизнес, хүний эрхийг урагшлуулахад худалдааны салбар маш чухал үүрэгтэй гэж бодож байна. Энэ нь цаашлаад илүү өсөх нь чухал байна. Тийм учраас ЕХ явуулж буй үйл ажиллагаагаараа улс төр, худалдааны хөтөлбөрөө талбарууд дээр илүү үр нөлөөтэй болгож байгаа нь маш үр дүнтэй байгаа бөгөөд миний бодлоор тогтворжих юм бол улам ч үр нөлөөтэй болно гэж би үзэж байна. Үнэхээр чухал, зөв зүйтэй зүйл учраас компаниуд бизнес хүний эрхийн ажлыг илүүтэй өрнүүлдэг болоосой гэж найдаж байна. Энэ ч маш ухаалаг алхам байх болно. Ингээд би яриагаа өндөрлөө.



Хурал зохион байгуулагч:

Одоо бидний арга хэмжээний дараагийн хэсэг буюу панел хэлэлцүүлэг маань эхлэхэд бэлэн болсон байна.

Төр, хувийн хэвшил, хандивлагч байгууллага болон “Бизнес ба хүний эрх” хөтөлбөрийн төлөөлөл оролцох энэхүү хэлэлцүүлэг маань хүний эрхийн асуудал яагаад бизнест хамааралтай вэ гэдэг сэдвээр өрнөнө. Хэлэлцүүлгийг ГХЯ-ны Гадаад худалдаа эдийн засаг хамтын ажиллагааны дарга В.Оюу удирдан чиглүүлэх болно. Хэлэлцүүлэгт оролцох зочдоо товчхон танилцуулья.

Хэлэлцүүлэгт оролцогчид:

- Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газрын дэд Тэргүүн Марко Ферри
- Хүний эрхийн үндэсний комиссын олон улсын гэрээ, Эрхзүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ө.Ундрах
- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч О.Амартүвшин
- Европ-Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх Захирал Томаш Бравенек
- Бизнес ба хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн Гишүүн, хүний эрхийн Хуульч С.Мойлтмаа нар оролцох болно.

Ингээд В.Оюу даргыг хэлэлцүүлгээ эхлүүлнэ үү хэмээн урьж байна.



“БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ” ХӨТӨЛБӨРИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ ЦАХИМ НЭЭЛТ

ПАНЕЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ ЯАГААД БИЗНЕСТ ХАМААРАЛТАЙ ВЭ?



В.ОЮУ

Гадаад Харилцааны Яамны Гадаад Худалдаа Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Газрын Дарга



МАРКО ФЕРРИ

ЕХ-ноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн Газрын Дэд Тэргүүн



Ө.УНДРАХ

Хүний Эрхийн Үндэсний Комиссын Захиргаа, Хамтын Ажиллагааны Газрын Дарга



О.АМАРТҮВШИН

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгч



ТОМАШ БРАВЕНЕК

Европ-Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Гүйцэтгэх Захирал



С.МОЙЛТМАА

Бизнес ба Хүний Эрхийн Үндэсний Хөтөлбөр боловсруулах Ажлын Хэсгийн Гишүүн, Хүний Эрхийн Хуульч

Арга хэмжээг дэмжигч байгууллагууд:



Панел хэлэлцүүлэг:

ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ ЯАГААД БИЗНЕСТ ХАМААРАЛТАЙ ВЭ?

Чиглүүлэгч



В.ОЮУ

**ГХЯ-ны Гадаад Худалдаа
Эдийн Засгийн Хамтын
Ажиллагааны Газрын
Дарга**

Манай панелд 50 минут олгогдсон. Хүн бүр 5 минутаар өөр өөрсдийн мэдээллийг хийнэ. Мэдээлэл хийсний дараа оролцогчид болон панелийн дунд нэмэлт асуулт, саналаа ярилцах 10-20 минут үлдэх болно. Тиймээс би өөрийн мэдээллийг шууд эхлэе.

Бизнес хүний эрхийн асуудал худалдааны бодлоготой ямар холбоотой юм бэ? Энэ сэдвээр 5 минут товч мэдээлэл хийгээч гэж надаас хүссэн юм.

Хүн ам цөөн, жижиг эдийн засагтай, жижиг зах зээлтэй манай улсын хувьд худалдаа бол цусны эргэлт шиг чухал үүрэг гүйцэтгэдэг. Өнөөдөр манай орны гадаад худалдаа дотоодын нийт бүтээгдэхүүний 125%-г эзэлж байна. Валютын орлогыг бараг бүхэлд нь гаргадаг. Төсвийн орлогын 30-40%-ийг бүрдүүлж байна. Энэ ч утгаараа эдийн засгийн өсөлт хөгжил, бүс нутгийн хөгжил орлогын ялгааг бууруулах, жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх, шинэ технологи ур чадварыг бэхжүүлэх гээд олон талаараа худалдаа бол чухал ач холбогдолтой гэж бид үздэг. Нөгөө талаар худалдааны либералчлал татаасын бодлогын зохицуулалтыг бид зөв зохицуулж явахгүй бол төсвийн орлого буурах, дотоодын үйлдвэрлэл унах, хүмүүс амьжиргаагаа алдах гээд сөрөг үр дагаврууд үүсч байна. Энэ бол зөвхөн манай орны хувьд биш олон улсын түвшинд ийм асуудлууд үүсдэг. Иймд худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал нь хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, амьд байх эрх, эрүүл байх эрх, өмч хөрөнгөтэй байх, оюуны бүтээлээ өмчлөх түүнийгээ үнэлэх, мөн хөдөлмөрийн сайн нөхцөлөөр хангагдах, мэдээлэлтэй байх, үг хэлэх гэх мэт хүний олон эрхүүдийг хөнддөг асуудал юм. Дэлхийн худалдааны байгууллагын маргаан шийдвэрлэх механизмын хүрээнд ч гэсэн худалдааны маргааныг шийдвэрлэхдээ хүний эрхийн нөлөөллийг авч үзэж эхлэж байна.

Ер нь худалдааны бодлого шийдвэрийн үнэлгээнд хүний эрхийн нөлөөллийн судалгаа шинжилгээг ашиглах явдал ч гэсэн нэлээн түгээмэл болж байгаа юм. Өнөөдөр Засгийн газраас худалдаа хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд тоймтой гурваас дөрвөн тэргүүлэх зорилтыг дэвшүүлж байна.

Үүнд үйлдвэрлэл экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, нэмүү өртгийг бий болгох. Экспортын зах зээлийг тэлэх хүрээнд харилцан ашигтай чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулах. Худалдааны хөнгөлөлттэй нөхцөлүүдийг оновчтой ашиглах. Энэ экспортын зах зээлүүдээс худалдааны хөнгөлөлттэй нөхцөлүүдийг нэмж авах. Бүс нутгийн интеграцад нэгдэх, худалдаа хөрөнгө оруулалтын үйлдвэрлэлийн сүлжээнд нэгдэх, гадаадын хөрөнгө оруулалт зээл хөгжлийн хамтын ажиллагааг энэ чиглэл рүү энэ зорилтыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй оновчтой чиглүүлэх зорилтуудыг тавьж ажиллаж байна. Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүний эрхийн асуудал яаж хөндөгдөж байна? Хэрхэн яаж хүний эрхийн асуудалдаа тодорхой хэмжээгээр анхаарал тавьж, бодож анхаарч явах ёстой юм бэ гэдгийг хоёр гурван жишээн дээр хэлье.

Юуны өмнө худалдааны хөнгөлөлттэй нөхцөлийн хувьд хоёр жишээ авъя.

“ 2005 оноос хойш ЕХ-ны худалдааны хөнгөлөлтийн системийг бид нар эдлэж байна. 7200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнд бид ЕХ-ны зах зээл дээр хөнгөлөлттэй нөхцөлөөр гарах боломжийг ашигладаг. 2020 оны байдлаар манай экспортлогч нар 127 сая ам долларын бараа бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр экспортолсон. ”

Нийтдээ 38,8 сая ам долларын хөнгөлөлт эдэлжээ гэж бид харж байна. Энэ хөнгөлөлтийг авахын тулд Монгол Улс нэгдэн орсон хүний эрх, хөдөлмөрлөх эрх, мөн сайн засаглалын 27 конвенцын хэрэгжилтийг сайн хангасан, сайн хэрэгжүүлсэн байх ёстой гэсэн шаардлагыг урьдчилсан нөхцөл болгож тавьдаг. Хоёр жил тутам энэ 27 гэрээ конвенцын хэрэгжилтийг гаргаж Европын Комисст хүргүүлдэг. Европын Комиссоос хоёр жил тутамд ирж мониторинг хийдэг. Монгол улс ЕХ-той жил тутамд худалдаа хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны механизмыг хуралдуулдаг.

Энэ хүрээнд хөнгөлөлтийн ерөнхий систем, худалдаа хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх системийг хэлэлцэхээс гадна хүний эрхийн асуудлыг зайлшгүй энэ механизмын хүрээнд авч хэлэлцдэг. Иймээс худалдаа хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх суурь нөхцөл бол хүний эрхийг хангах, хариуцлагатай байх шаардлага бидний өмнө тавигддаг. АНУ-ын зах зээл дээр 3400 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг бид нарт гаалийн татваргүй гаргах нөхцөл олгогдсон.

2020 оны байдлаар 4,1 сая ам долларын оёмол, сүлжмэл, ноос ноолууран бүтээгдэхүүнийг бид Америкийн зах зээл дээр гаргасан. Арьс ширний үйлдвэрлэл дээр гангийн баяжмал, малын тоноглол гэх мэт бидний хараахан ашиглаж амжаагүй байгаа бүтээгдэхүүнийг Америкийн зах зээл дээр гаргах бүрэн боломжтой. Америкийн GSP Plus-ийн урьдчилан тавьж байгаа нөхцөл бол Монгол Улс хөдөлмөрлөх эрх, ялангуяа хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс, ажиллагсдад эвлэлдэн нэгдэх эрхийг олгосон байх ёстой. Хүүхдийн хөдөлмөр болон албадан хөдөлмөр эрхлэлтийг үл тэвчсэн бодлоготой орон байх ёстой гэсэн шаардлагыг бидэнд тавьдаг.

АНУ-ын төрийн департамент, Хөдөлмөрийн яамнаас Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал мөн хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийн талаар тогтмол тайлан гаргадаг. Бидэнд тодорхой хэмжээгээр үнэлгээ өгч, зөвлөмж өгөөд явдаг.

Чөлөөт худалдааны хэлэлцээр, экспортын зах зээлийг төрөлжүүлэх, экспортын зах зээлийг тэлэх асуудал бол манай худалдааны бодлогын тэргүүлэх зорилтуудын нэг. Үүнийг бид тэргүүлэх зорилтоо болгосоор ирсэн. Ирэх цаг хугацаануудад ч бас энэ асуудал бидний хамгийн том зорилго байх ёстой. Хүний эрхийг хүндэтгэж, хамгаалах нь худалдаанд гадаад зах зээлийг нээлттэй байлгах шинээр зах зээлийг өргөжүүлэхэд найдвартай бөгөөд үр дүнтэй арга гэж олон улсын хэмжээнд үздэг. Хүний эрхийн ноцтой зөрчилтэй бол аль нэгэн худалдааны түнш улс орон бүс нутгаас бидэнд хориг тавих магадлалтай. Хэдийгээр энэ нь худалдааны шинж чанартай, эдийн засгийн шинж чанартай арга хэмжээ биш ч гэсэн улс төрийн хүчтэй энэ шийдвэр бол худалдаанд маш том хориг болж орж ирдэг. Тиймээс шинэ зах зээлийг нээх, экспортынхоо зах зээлийг өргөжүүлэхийн тулд зайлшгүй энэ асуудлуудыг бодож байх ёстой.

Монгол Улс өнөөдрийн байдлаар Япон улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан. Япон улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрт хоёр улс харилцан бие биедээ хөрөнгө оруулалт хийхдээ өнөөдөр мөрдөж байгаа эрүүл ахуй болон аюулгүй байдал, хэрэглэгчдийн аюулгүй байдал, байгаль орчин мөн хөдөлмөрийн салбарт тавигдаж байгаа стандартуудаа ямар нэгэн байдлаар сулруулж болохгүй гэсэн ийм нөхцөлийг тал талдаа хүлээн зөвшөөрөөд байна. Цаашид чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудал бол гадаад худалдааны бодлогын тэргүүлэх зорилго байна гэдгийг түрүүнд хэлсэн.

Тиймээс чөлөөт худалдааны хэлэлцээрийн багийг бүрдүүлэх, чадавхыг дэмжих, багийн бүтэцтэй болох, дээрээс нь энэ багаа бодлогын удирдамжаар хангаж явахдаа бид нар энэ хүний эрхийн шаардлагуудыг заавал харгалзаж үзэх ёстой гэж үзэж байна. Нэг талдаа бид дотроо гэрийн даалгавраа хийгээд бэлтгэлээ хангаж байна. Нөгөө талдаа бидэнтэй чөлөөт худалдаа хийх гэж байгаа гадна талд маань энэ асуудлууд шаардлага болоод тавигдаж орж ирэх юм.



Шинэ Зеланд зэрэг орны жишээг харахад чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахдаа олон нийтийн оролцоо, олон нийтийн саналыг заавал сонсдог, үндэсний цөөнх, хүн амын бүлгүүдийн саналыг заавал сонсдог, дээрээс нь чөлөөт худалдааны хэлэлцээр дотор хөдөлмөрлөх эрх болон байгаль орчныг хамгаалах асуудал бол заавал нөхцөлдөж орж ирэх ёстой гэсэн ийм шаардлагуудыг тавьж байна. Иймд чөлөөт худалдааны хэлэлцээрийг бид урдаа зорилго болгож тавьж байгаа бол энэ асуудлыг заавал бодож явах ёстой гэж миний хувьд үзэж байгаа юм.

Зөвхөн чөлөөт худалдааны хэлэлцээр ч биш хоёр талын хөрөнгө оруулалтын хэлэлцээр худалдааны хэлэлцээрүүд дээр бид нэлээн анхаарах ёстой гэж боддог. Европын Холбооны дэмжлэгтэй бидний хэрэгжүүлж байгаа худалдааг дэмжих төслийн хүрээнд хүнсний бус бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хамгаалах ажлын хүрээнд мэргэжлийн хяналтын ерөнхий газар дээр хуулийн төслийг боловсруулаад явж байна. Энэ хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулаад холбогдох судалгаануудыг хийсэн. Улаанбаатар хот дахь эмнэлгүүдээр явж, яг хүнсний бус бүтээгдэхүүнээс болоод эрүүл мэндийн хувьд хохирсон хохирогч, эмчлүүлэгч нартай уулзаад явахад зарим нэр төрлийн бүтээгдэхүүнүүд, ялангуяа хүүхдийн тоглоомууд, зарим арьс ширэн бүтээгдэхүүнүүд, гоо сайхны бүтээгдэхүүнүүд мөн хувцас хэрэглэлээс ч шалтгаалж хүмүүсийн эрүүл мэнд асар ихээр хохирсон статистик тоон мэдээлэл гарсан.

Иймд худалдааны гэрээ хэлцлийг хийхдээ хэдийгээр энэ асуудлууд хил гаалийн хяналтын асуудлуудтай холбоотой, худалдааны өөрийн тарифын бус хориг саад тавих ёстой асуудал хэдий ч үүнийг бид заавал бодолцох ёстой. Хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүдийг бид хөрөнгө оруулалтын орчныг урьдчилж харж болохуйцаар байлгахын тулд хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд дээр энэ асуудлыг анхаарах хэрэгтэй. Ямар хөрөнгө оруулагч, ямар түүхтэй, энэ компани хаана ямар үйл ажиллагаа явуулж байсан бэ гэдгийг бодолцохгүй бол зарим хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд дээр өнөөдөр бидэнд тулгамдаад буй асуудлуудаас дүгнэлт хийхэд энэ асуудлуудыг заавал бодолцох ёстой гэж болж байгаа юм.

Гадаадын хөрөнгө оруулалт, зээл болон хөгжлийн хамтын ажиллагааг энэ худалдаа хөрөнгө оруулалтын зорилтуудад оновчтой чиглүүлэх ёстой гэсэн бодлогын зорилт бий. Үйлдвэрлэл экспортыг төрөлжүүлэх, нэмүү өртгийг бий болгохын тулд бидэнд зайлшгүй санхүүжилтийн эх үүсвэрүүд шаардлагатай. Гэхдээ бидэнд олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас зээл өгөхдөө хүний эрх, хариуцлагатай байдлыг зайлшгүй шаарддаг. Манай томоохон аж ахуйн нэгжүүд, уул уурхайн компаниуд энэ шаардлагуудыг зээл авахын өмнө биелүүлээд явж байгаа гэж бодож байна. Энэ бол зөвхөн зээл авахын төлөө цаг үеийн асуудал байж болохгүй. Үүнийг компанийнхаа, бизнесийнхээ дадал соёл болгох ёстой гэж үзэж байна. Мөн бизнесээ өргөжүүлэх, хөрөнгө оруулалт босгох нэг гол хэрэглүүр бол хувьцаа, үнэт цаас гаргах асуудал байдаг. Олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас тавьж байгаа энэ шаардлага нь олон улсын хөрөнгийн биржүүд мөн манай дотоодын хөрөнгийн бирж дээр ч гэсэн тавигдаж эхэлж байна. Монголын хөрөнгийн бирж энэ чиглэлээр тодорхой санал санаачилга гаргаад ажиллаж байгаа гэж бодож байна.

Бүс нутгийн интегралчлал, худалдаа хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн сүлжээнд нэгдэх зорилтыг бид тавьсан.

“

Олон бизнесийн байгууллагуудын хүний эрхийн бодлого нь бизнесийн бүх түнш, бүх салбар, бүх сүлжээний шатуудад хүний эрх хөдөлмөрлөх эрх болон хөдөлмөрийн стандартуудыг хэрэгжүүлсэн байхыг шаардаж байна. Хэрвээ бид олон улсын нийлүүлэлтийн болон хөрөнгө оруулалтын сүлжээнд нэгдэж орё гэвэл зайлшгүй хариуцлагатай байх ёстой. Эргээд хөрөнгө оруулж байгаа компаниудаасаа шаардаж хамтарч ажиллах ёстой.

”

Чиглүүлэгч Б.Оюу: Манай панелд оролцож байгаа таван хүнээс хүний эрхийн асуудал яагаад бизнест хамааралтай вэ сэдвийнхээ хүрээнд асуулт асуух саналтай байна. Хамгийн түрүүнд ноён Марко Ферригээс асууя.

- Ноён Марко Ферри 2015 оноос хойш Монгол Улс Европын Холбооны хамтын ажиллагааг хариуцаж ажиллаж байна. Европын Холбооны худалдааны хөнгөлөлттэй системийн талаар би сая мэдээлэлдээ дурьдсан. Өнөөдөр бид энэ хөнгөлөлтийн системийг ашиглаж байна. Цаашдаа илүү ашиглах орон зай боломж бидэнд бий. Ер нь Бизнес хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр"-тэй болох, манай бизнесүүд, манай компаниуд, Монголд бизнесийн орчин хариуцлагатай болох нь Европын Холбоо болон Монгол улсын худалдаа хөрөнгө оруулалтын харилцаанд яаж нөлөөлнө гэж та харж байна вэ?



МАРКО ФЭРРИ

Европын Холбооноос
Монгол Улсад суугаа
Төлөөлөгчийн газрын
дэд Тэргүүн

Таны асуусан асуултанд баярлалаа.

Мөн Монголын талаарх суурь мэдээллийг тайлбарласанд баярлалаа. Би нэг түүхээр хариултаа эхлүүлье. Би Европын институтуудад ажиллаад 25 жил болж байна. Миний хувьд гуравдагч орнуудын ажил эрхлэлт, нийгмийн зөвшилцлийн асуудлуудыг хариуцан ажилладаг байсан. Энэ бол удирдамж, зарчмуудыг гарахаас аль өмнөх эртний асуудал. Тухайн үед бид АНУ, Японтой гэрээтэй ажиллаж байлаа. "Яагаад" энэ хоёр улс гэж асууж магадгүй. Яагаад гэвэл тэр үед АНУ, Япон хоёр ЕХ-ны улсын хамгийн том худалдааны түншүүд байсан. Европын хэрэглэгчид нийгмийн түншлэлүүд болох худалдааны эвслүүдээс гадаад улсуудад үйлдвэрлэгдэн ЕХ-д экспортолж байгаа бараа таваараас нэг л хүлээлттэй байсан нь бүгд нэг стандарттай байх зарчмыг баримталдаг байв. Эсвэл дор хаяж ЕХ-той харьцуулагдахаар ойролцоо стандартыг баримтлах ёстой хэмээж байв. Бид энд ЕХ-ны стандартыг дэлхийн хэмжээний стандарт болгох тухай яриагүй гэдгийг хэлье. Бидэнд INO-ын лавлах заалтын дагуу олон улсын импортын стандартууд болон бусад стандартууд байсан.

Та нар анекдот (онигоо) сонирхож байвал тэр үед буюу 2005 онд би Хятадтай ажилгүйдэл, нийгмийн зөвшилцлийн талаар ажиллаж байсан юм.

Яагаад вэ? Яагаад гэвэл Хятад улс ЕХ-ны хамгийн том түнш болсон учраас тэдний үйлдвэрлэж, ЕХ-д экспортолж байгаа бараа бүтээгдэхүүн нь ямар нэг хүчирхийлэл зөрчлийн дор үйлдвэрлэгдэж, ялангуяа ажилчдын хөдөлмөрийн стандарттай холбоотой асуудлаар зөрчилгүй байлгахыг хүссэн учраас тэр байв.

Тэгэхээр ЕХ-ны хувьд бизнес хүний эрхийн талаарх ойлголт, түүхэн замналын ард талд чухам юу байсныг сонирхуулахад ийм байна. Өнөөдөр бид бүх бизнес эрхлэгчдийг буюу үндэстэн дамнасан олон улсын болон дотоодын бүх бизнес эрхлэгчдийг НҮБ-ын удирдамж, зарчмууд, “Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага” (ILO) гуравдагч талуудын тунхагт тааруулах зарчмуудыг баримтлахыг, UNCD зарчмуудад хүний эрхийг уялдуулах, бизнест тавигдах зайлшгүй шаардлагаар хүний эрхийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх үйл ажиллагааг явуулахыг уриалж байна гэж ярьдаг.

Би та бүхэнд би тогтвортой бизнес, хүний эрхийн хөтөлбөр, бизнест сонирхолтой болгох зарим шалтгаан буюу дахиад дор хаяж дөрвөн шалтгааныг хэлье. Компаниуд хүний эрхийн тухайд бүгд амжилттай байх үйлст хувь нэмрээ оруулах сонирхолтой байдаг гэдэгт бид итгэлтэй байна. Энэ шалтгааны улмаас тэд бүгдэд хүний эрх, нийлүүлэлтийн сүлжээг найдвартай тохируулах сонирхол өсөн нэмэгдсээр байна.

Нэгдүгээрт ажил олгогчид өөрсдийн ажилчид, засгийн газруудтай нийгмийн шударга ёсыг дэмжих зорилтууд, олон улсад зөвшөөрөгдсөн хүний эрх, хөдөлмөрийн эрх, зарчмуудыг сахин биелүүлэх үйлсийг сайжруулахыг хамтдаа хуваалцаж байна.

Хоёрдугаар шалтгаан нь улс орнууд хүний эрх, эдгээрийн дотор иргэний, улс төр, эдийн засаг, нийгмийн эрх, олон улсын ILO стандарт, мөн үйл ажиллагаа, хууль эрхийн бүтцүүдийг бий болгохдоо хууль боловсруулагчид хууль батлах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон улсын холбогдох хэм хэмжээсүүдэд тохируулахдаа хүний эрхийн баталгааг хангаж байгаа шалтгаан байна. Тиймээс улс орнуудад компаниуд олон улсын хүний эрхийн стандартад өөрсдийн үйл ажиллагааг тохируулах үүргийг илүүтэйгээр хүлээгээд байна.

Гурав дахь шалтгаан нь хэрэглэгчид хүний эрхийг хүндэтгэн дээдлэх сонирхол нь улам нэмэгдэж байна. Өмнө нь бид хэрэглэгчид гэхдээ Европын холбооны хэрэглэгчдийг хэлдэг байв. Тэгвэл одоо Азийн хэрэглэгчид энэ талаар илүү их сонирхдог болж корпорацуудын нийгмийн хариуцлага, эсвэл хариуцлагатай бизнесийн талбарт илүү их анхаарал хандуулах болжээ.

Дөрөв дэхь шалтгаан нь банк, олон улсын санхүүгийн байгууллагууд эдийн засаг, нийгэм, засаглалын асуудлуудтай үйл ажиллагаагаа нийцүүлэн тохируулах шахалт шаардлагын дор ажилладаг болоод байна.

Монгол улсын хувьд жагсаалтын нэлээд алдартай хэсгийг санаарай. Энэ бол авилгалын тухай юм. Бид авилгал, хүний эрхийг бодож болно. Бид сайн засаглалыг хүний эрхтэй холбож бодож болно. Үүний жишээ нь авилгал байна. Тэгвэл жагсаалтын нэг хэсэг нь банкууд хэрхэн сонирхож байгаа жишээ байна. Би Олон улсын хөдөлмөрийн байгууллагад (ILO) ажиллаж байх үеийн хэдэн жишээн дээр ярья. Тухайлбал хөдөлмөрийн стандартын жишээ нь бизнесийнхний сонирхлыг татдаг учраас үүнтэй холбоотой жишээ хэлье. Хөдөлмөрийн стандартууд нь нийгмийн хөгжилд үнэ цэнэтэй байдаг ч тэд мөн эдийн засгийн зорилтуудад хүрэхэд хувь нэмэр оруулах боломжтой учраас бизнес, зах зээлийн үйл ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмэртэй байдаг.

Хэдийгээр эдгээрээр хязгаарлагдахгүй ч эдийн засгийн эдгээр үр ашиг нь ОУХБ-ын үндсэн зөвшилцөлд илэрхий байдаг. Эхний жишээгээ авъя. Холбоодын эрх чөлөөг тодорхойлсон хэд хэдэн зөвшилцөлд Монгол Улс нэгдэн орсон байдаг. Худалдааны эвлэл, хамтарсан талуудын тухайд юм. Тухайлбал ардчилал, чөлөөт сонголт, хуулийн дүрэмд хувь нэмэр оруулах бөгөөд бид зөв тохиромжтой зах зээлийн эдийн засагт оролцож байна. Нэмж хэлэхэд хөдөлмөрийн эдгээр стандартуудыг сахин биелүүлснээр илүү үр дүнтэй ажиллагаатай зохион байгуулалт, санаачилгыг дэмжих орчныг бид бүтээж чадна.

Эцэст нь хөрөнгө оруулалтыг хамгаалахад тусалж, бизнес эрхлэгчдийн тохируулалтыг зохицуулах тухайлбал үндэсний хямрал эсвэл эдийн засгийн хямрал гэх мэтэд тусалж, нийгмийн аюулгүй байдалд хувь нэмэр оруулах идэвхтэй боломжууд бидэнд байна.

ОУХБ-ын хөдөлмөрийн стандартаас өөр жишээ авч болж байгаа нь ялгаварлан гадуурхлыг үгүй хийх юм. Монгол улс ОУХБ-ын ялгаварлан гадуурхахын эсрэг таван конвенцод нэгдсэн. Ялангуяа эмэгтэйчүүд, цөөнхийн тухай конвенцууд юм. Эдгээр нь хүний нөөцийн ачаалал, хуваарилалтыг сайжруулж, эдийн засгийн үр дүнг өсгөх боломжтой.

Олон улсын хөдөлмөрийн стандартын хувьд үүнтэй адилхан хүчин төгөлдөр асуудал нь албадан хөдөлмөр эрхлүүлэлт ба үүнийг үгүй хийх тухай юм. ОУХБ-ын бүлэг конвенцоос өмнө өөр нэг конвенц байсан нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн тухай бөгөөд бүхэл талбарын хүний эрхээс гадна хүүхдийн хөдөлмөрийн журмын конвенцын хэрэгжүүлэлт бөгөөд энэ нь боловсрол сургалттай холбогддог. Тэдгээр нь дараагийн ажилчин үеийн чадварыг сайжруулан сургах ажиллагаа бөгөөд улс орны эдийн засгийн хөгжилд эерэг хүчин зүйлийг авчрах боломжтой. Энэ бол миний хувьд онцгойлон чухалчилдаг талбар юм. Би олон жил эдгээр асуудлууд дээр ажиллаж байна.

“

Тиймээс бизнесийн байгууллагууд хүний эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээрийг дарамт шахалт гэж үзэхгүйгээр компанийнхаа үр дүнг нэмэгдүүлэх хэрэгсэл гэж харах шаардлагатай.

”

ЕХ та бүхэнтэй мөр зэрэгцэж байгаа учраас энэ төслийг хэрэгжүүлж байгаа билээ. Тогтвортой хөгжлийн зорилтуудын өргөн хүрээний ажлын нэг хэсэг нь корпорацийн нийгмийн хариуцлага, бизнесийн хариуцлагыг дэмжих учраас бид үргэлжлүүлэн дэмжих болно. ТХЗ-уудыг хэрэгжүүлэх бүх хэрэгслийг бид мартаж ёсгүй учраас бид оролцогч талуудтай нэгдэн дутагдлыг илрүүлэхэд хамтран ажиллаж байна. Тиймээс эдгээр бүх хүмүүсийн хуваалцаж байгаа энэ бүх чухал шаардлагуудыг Монгол Улс үйл ажиллагаандаа тусган ажиллана гэж найдаж байна. Та бүхэнд баярлалаа.

Чиглүүлэгч В.Оюу. Баярлалаа Марко. Бидэнд цөөхөн минут ярилцах хугацаа байна.

Чиглүүлэгч В.Оюу: Дараагийн панелист Хүний эрхийн үндэсний комиссын захиргаа хамтын ажиллагааны газрын дарга Ө.Ундрахыг урья. Хүний эрхийн үндэсний комисс 2015-2018 онд хүний эрхийн үндэсний байгууллагуудын дэлхийн холбооны бизнес ба хүний эрхийн ажлын хэсэгт Ази номхон далайн бүс нутгаа төлөөлж байсан. Энэ ажлыг Ундрах дарга хариуцаж байсан. Тэрээр Бизнес ба хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэх хорооны ажлын хэсгийн гишүүн юм.

- Ө.Ундрах даргаас бизнесийн үйл ажиллагаанаас үүсэх хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх тал дээр Хүний Эрхийн Үндэсний Комиссын чиг үүрэг ямар байгаа вэ гэдгийг тодруулан асууя.



Ө.УНДРАХ

Хүний эрхийн
үндэсний комиссын
олон улсын гэрээ,
Эрхзүй, хамтын
ажиллагааны
хэлтсийн дарга



Бизнесийн үйл
ажиллагаанаас үүдэлтэй
хүний эрхийн асуудлыг

эн тэргүүнд хүний эрхийн үндэсний байгууллагын үндсэн чиг үүргийн үүднээс авч үзэх нь зүйтэй юм. Нэн тэргүүнд хүний эрхийн үндэсний байгууллагын хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, илтгэх тайлагнах чиг үүрэг үүнд хамаарна.

Хүний эрхийг хамгаалах чиг үүргийн хүрээнд гомдол хянан шийдвэрлэх үйл ажиллагааны хүрээнд хүний эрхийн зөрчлүүдтэй тулж ажилладаг. Гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бол Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний хэнээс ч хараат бүсаар, зөвхөн Комиссын чиг үүргээс үл хамааран хэрэгжүүлдэг эрх хэмжээ юм. Энэ бол зөрчигдсөн эрхийг сэргээдэг гол механизм юм. Гэвч хүний эрхийн үндэсний аливаа байгууллагын хувьд аливаа гомдол хянан шийдвэрлэх үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд хуулиар харъяалан шийдэх асуудал, харъяалан шийдэх боломжгүй асуудал гэж байдаг. Хүний эрхийн Үндэсний Комиссын хувьд бизнесийн байгууллага, төр, хувийн хэвшил болон бусад үүрэг хүлээгч талуудаас үүсэлтэй аливаа хүний эрхийн зөрчлийг хянан шийдвэрлэх эрх хэмжээ байх боловч зөрчил буюу гэмт хэргийн шинжтэй асуудлыг харъяалалын дагуу шилжүүлэх үйл ажиллагаа явдаг.

Олон улсад хүний эрхийн үндэсний байгууллага нь анх үүсэн байгуулагдаж, хөгжих явцад ялангуяа хүний эрхийн үндэсний байгууллагын үндсэн хууль гэж үзэхүйц баримт бичиг болох Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Парисын Зарчмыг 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас баталсан бөгөөд уг зарчмын дагуу Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбооны зүгээс хүний эрхийн үндэсний байгууллагыг магадлан итгэмжилж ажиглалт дүгнэлт, зөвлөмж гаргахдаа гомдол хянан шийдвэрлэх үйл ажиллагаа, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд төр болон хувийн хэвшлийн байгууллага болон бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг тодорхойлж ирсэн болно. Олон улсын хамтын нийгэмлэг 2011 онд Бизнес ба хүний эрхийн удирдлага зарчмыг баталж, мөн Олон Улсын Эдийн Засгийн Хөгжил, Хамтын Ажиллагааны Байгууллагаас гаргасан удирдамжид нэмэлт өөрчлөлт орсонтой зэрэгцэн 2010 онд Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбоо Бизнес ба хүний эрхийн чиглэлээр хүний эрхийн үндэсний байгууллагуудын гүйцэтгэх үүрэг ролийг тодотгон томъёолж, Эдинбургийн тунхаглалыг баталж гаргасан.



Өнөөгийн үндэсний болоод бүс нутаг, олон улсын шинжтэй бизнесийн хүрээнд хүний эрхийн олон асуудлуудын хамрах хүрээ нь бол маш өргөн бөгөөд аж ахуй эрхлэх, хөдөлмөрлөх эрх, бизнесийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөж буй хүмүүсийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, өөрсдийн аж ахуйгаа эрхлэх, хөдөлмөрлөх эрх гэх мэт маш олон эрхийг хөнддөг. Цаашлаад сүүлийн үед хурцаар тавигдах болсон уур амьсгалын өөрчлөлттэй хүртэл холбогддог чухал асуудал юм. Тиймээс бизнесийн үйл ажиллагаанд хөндөгдөж буй хүний эрхийн асуудлыг бүс нутгийн болоод олон улсын хэмжээнд ялангуяа хүний эрхийн үндэсний байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд зохицуулах шаардлагын үүднээс Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбооноос гаргасан Эдинбургийн тунхаглал болон 2015 онд НҮБ-аас баталсан Эх дэлхийгээ өөрчлө: Тогтвортой хөгжлийг зорилтуудтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбооноос гаргасан Меридагийн тунхаглал, мөн бизнесийн байгууллага болон үйл ажиллагааны хүрээнд хөндөгдөх хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын асуудлаар хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2018 онд гаргасан Марракешийн Тунхаглал зэрэг бичгүүдэд энэ асуудлуудыг тусгасан байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс эдгээр бүс нутгийн болоод олон улсын гишүүнчлэл бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох явцдаа 2015-2018 онд Хүний эрхийн Үндэсний Байгууллагуулын Дэлхийн Холбооны сонгуульт үйл ажиллагааны хүрээнд тус байгууллагын Бизнес ба хүний эрхийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орон ажиллаж, манлайлал үзүүлсэн юм. Хүний эрхийн Үндэсний Комиссын хувьд хүлээн авч байгаа гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны болон хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд явуулсан үйл ажиллагаа бол үндсэндээ судалгаа хяналт шалгалт гэсэн цогц үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж ирсэн болно. Энэ чиглэлийн үйл ажиллагааны хүрээнд 2012 онд НҮБХХ-тэй санхүүжилттэй “Монгол Улс дахь хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд уул уурхайн бизнесийн хүрээн дэх хүний эрхийн нөхцөл байдалд судалгаа, хяналт шалгалт хийж үр дүнг нь 2012 оны 10 дугаар сард зохион байгуулсан “Уул уурхайн бизнес ба хүний эрх” сэдэвт олон улсын бага хуралд авч хэлэлцсэн болно. Дээрх хурлаар НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдлага зарчмыг төр, хувийн хэвшил болоод иргэний нийгмийн байгууллага зэрэг бизнесийн хүрээнд хүний эрхийн асуудалд оролцогч бүх тал тус бүрийн хамаарах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон юм.

Мөн 2015 оны НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын тайланг хэлэлцээд өгсөн зөвлөмжийн дунд Бизнес ба хүний эрхийн удирдлага зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө батлах зөвлөмж өгснийг Монгол Улс хүлээн авсны үр дүнд Комиссын өгч байсан дээрх зөвлөмж хэрэгжих нөхцөл бололцоо бүрдээд байна.



Цаашид Хүний эрхийн Үндэсний Комиссын бизнесийн хүрээн дэх хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг хянан шийдвэрлэх, таслан зогсоохтой холбоотой үйл ажиллагаа нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд хүний эрхийн хамгаалагч, уур амьсгал тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг олон талын асуудлын хүрээнд хэрэгжих юм.



НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдлага зарчмын шүүхийн бус үйл ажиллагаа буюу гомдол хянан шийдвэрлэх зарчим нь Хүний эрхийн Үндэсний Комисст зайлшгүй хамаарна. Зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс хүний эрхийг хөхиүлэн дэмжих эрх хэмжээнийхээ хүрээнд бизнесийн байгууллагуудын бизнесийн хариуцлагын зэрэгцээ заавал анхаарч хэрэгжүүлбэл зохих хүний эрхийн хянан магадлал гэх зарчим, үйл ажиллагаа нь Хүний эрхийн Үндэсний Комиссын олон талт хамтын ажиллагааны нэг хэсэг байх болно.

Чиглүүлэгч: Дараагийн панелист бол Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Амартүвшин юм. Амартүвшин ерөнхийлөгчтэй манай ажлын хэсгийн дарга ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга 2020 онд уулзсан. Уулзалтаар үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхэлж байна. Монгол дахь бизнесийн хамгийн том сүлжээ бизнес нэтворкийн хувьд та бүхэн энэ санаачилгыг дэмжиж ажиллаач гэсэн хүсэлт тавьсан. Амартүвшин ерөнхийлөгч бол Монголын бизнесийн байгууллагын төлөөлөл болсны хувьд энэ ажилд бизнесүүдээ манлайлж оролцоно гэж хэлсэн. МҮХАТ-ын дэд ерөнхийлөгч ажлын хэсгийн гүйцэтгэх хороонд орж ажиллаж байгаад танд их талархаж байна.

- Бизнес ба хүний эрхийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хамгийн гол нь төлөвлөгөө гарсны дараа зарчмыг хэрэгжүүлэх, бизнесийн соёлд нэвтрүүлэх ажил хамгийн чухал. Энэ ажилд МҮХАТ-ын зүгээс манлайлах, танхимын гүйцэтгэх үүрэг оролцооны талаар санал бодлоо хуваалцана уу?



О.АМАРТҮВШИН

Монголын Үндэсний
Худалдаа Аж Үйлдвэрийн
Танхимын Ерөнхийлөгч

Бизнес ба хүний эрх сэдвийг сүүлийн үед бүх түвшинд маш идэвхтэй ярьж байна. Монголд хувийн хэвшил үндсэндээ үүсгэн байгуулагдаад 30 гаруй жилийн л түүхийг үзэж байна. Бид энэ хугацаанд бизнесийн соёлоос соёлд суралцаж компаниуд шинэ түвшинд төлөвшиж ирлээ гэж хэлж болно. Яг энэ цаг үед бизнес ба хүний эрх гэдэг уялдаа холбоо бол байнга шинэ түвшинд яригдаж байна. Танхим дэргэдээ компанийн нийгмийн хариуцлагын зөвлөл ба комплесийн зөвлөл гэсэн 2 зөвлөлтэй.

Эдгээрээр дамжуулаад ер нь бид бизнесийг хүний эрхтэй яаж зөв ойлгуулах вэ? Компани, аж ахуйн нэгжүүд өнөөдөр хэрхэн шинэ түвшинд гарах ёстой юм бэ? Яаж суралцах вэ гэдэг энэ цаг үе ирсэн байна гэж харж байна. Өнөөдөр Монголын эдийн засгийг тэлэхийн тулд цоо шинэ дэглэмээр явж байна. Ковидоос бид цоо шинэ зүйл суралцаж байна. Бид зайлшгүй суралцах шаардлагатай болсныг харуулж байна. Сая дэлхийн эдийн засгийн форумд яригдсан нэг зүйл бол бүх зүйлийг шинээр эхлэх тухай юм.



Бидний хувьд Монгол улсад хөрөнгө оруулалт татах, экспортыг нэмэгдүүлэх нь компани бүрийн хүсэж байгаа зүйл. Тэгвэл үүнд хүний эрх гэдэг ойлголт ямар чухал вэ? Хүний эрх гэдэг зүйлийг хэрхэн зөв ойлгосноос бидний үйлчилгээ хэрхэн гадаад зах зээлд нэвтрэх вэ? Эсвэл гадны хөрөнгө оруулалтыг яаж татах вэ гэдэг дээр байнгын ойлголтыг өгөх ёстой юм байна гэдгийг хатуу ойлгож байна. Дээрээс нь хүний эрхийн суурь ойлголтууд болох бизнестэй холбогдох хөдөлмөрийн хуулиар дамжуулж хөдөлмөрийн хуулийн шинэ төсөл явж байгаа энэ үед бид өмнөх ажил олгогч, ажилтан гэдэг нь нэг нь хөлс төлдөг нөгөө нь хөлс авдаг гэдэг харилцаанаас илүүтэй хүний эрхэнд суурилсан цоо шинэ хөдөлмөрийн харилцааг шинэ хуулинд тусгаж байна. Үүнд танхим маш идэвхтэй ажиллаж байна. Ер нь өнөөдөр улс төр, нийгэм, эдийн засаг гээд бүхий л түвшинд уламжлалт хандлагаас дэлхий даяараа татгалзаж байна. Бизнесийн орчин ч бас үүнийг анхаарахгүйгээр өсөж, дэвжиж өдөлхийн зах зээлд хөл нийлүүлнэ гэдэг ойлголт байхгүй юм байна. Үүнийг Монголын аж ахуй нэгжүүдэд ойлгуулах, сургах, таниулах шаардлагатай. Энэ нь өөрөө ямар олон боломжуудыг бий болгодог гэдгийг таньж мэдүүлэх нь маш том, чухал ойлголт юм. Хөдөлмөрийн харилцаанд хүний эрхтэй холбоотой олон асуудлыг маш тодорхой тусгасан.



Та бүгдийн ярьж байгаачлан үндэсний цөөнх, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны бэлгийн дарамт, дээрээс нь бусад бэлгийн чиг хандлагын тухай нэн тодорхой тусгасан нь маш том дэвшил болж байна. Үүнийг өнөөдөр их төвөгтэй, ажил хийх орон зайгүй боллоо гэж харж байж магадгүй. Цаашдын ирээдүйд энэ нь том суурь боломж болох юм. Дэлхийтэй бид хөл нийлүүлж алхах ёстой. Үүний тулд бид хүний эрхийг дээдлэх хэрэгтэй. Хүний эрхийг дээдлэхгүйгээр цаашид ямар ч орон зайгүй болох юм байна гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Энэ асуудал зөвхөн бизнест биш нийгэм, төрд маш чухал гэдгийг ойлгуулах учиртай гэж бодож байна.



Бизнесийн нөхцөл байдалд цоо шинэ соёл болж байна. Өмнө нь магадгүй хэвийн мэт ойлгодог байсан зүйл өнөөдөр хэвийн биш болж хувирч байгааг та бүгд өнөөдөр нийгэмд өрнөж байгаа үйл явцаас харж мэдэрч байгаа байх. Өмнө нь бидний ердийн мэт ойлгодог байсан зүйл өнөөдөр биш болжээ. Хүний эрхийн маш өндөр мэдрэмжтэй үе бий болж байна. Энд аж ахуйн нэгжүүд бэлэн байна. Үүнийг маш хурдтайгаар сурталчлан таниулах тал дээр танхим өөрөөс шалтгаалах зүйлүүдийг хийж ажиллана гэж харж байна. Хүний эрхтэй холбоотой бизнесүүд нь хаагдаж, боогдож байгаа тохиолдлуудыг та бүхэн дэлхий даяар гарч байгаа мэдээллийн хэрэгслээр харж болно. Өнөөдөр уул уурхайн болон уул уурхайн бус экспортыг хийх улсууд бол Европын Холбооны улсууд, Япон, Америк байна. Магадгүй цаашлаад суурь шаардлага нь энэ асуудал болж болох юм. Тиймээс бид үүнийг суурь асуудал болгохгүйгээр дэлхийн улс орнуудтай хөл нийлүүлэн алхах боломжгүй юм гэж үзэж байна. Иймд МҮХАТ өөрөөс шалтгаалах бүх зүйлийг хийх болно гэж хариуцлагатайгаар хэлье.

Чиглүүлэгч: Дараагийн панелист бол Европ-Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал Томаш Бравенек. Томаш бол олон улсын банк санхүүгийн байгууллагад олон жил ажилласан туршлагатай. Европ-Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим нь 130 гаруй компанийг нэгтгэсэн байдаг. Түүний олонх нь манай дотоодын компаниуд байдаг.

- Ер нь “Бизнес хүний эрхийн асуудал” гэдэг нь Монголын бизнесийн хувьд юу гэсэн үг вэ?



ТОМАШ БРАВЕНЕК

Европ-Монголын
худалдаа аж үйлдвэрийн
танхимын гүйцэтгэх
Захирал



EUROCHAMBER MONGOLIA
ЕВРОП МОНГОЛЫН ХАМТАРСАН ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны өмнө намайг энэхүү чухал арга хэмжээний нээлтэд, Евро танхим, Европ, олон улсын байгууллагууд, Монгол улсыг багтаасан манай 700 гаруй гишүүдийг төлөөлүүлэн оролцохыг урьсанд маш их баярлалаа. Цагаа бодоод би шууд хатагтай В.Оюугийн асуусан асуултанд хариулахыг зөвшөөрнө үү. Европ, Монголын бүх оролцогч талууд болон гишүүдтэйгээ харилцах харилцаанаас бид хэд хэдэн чухал талыг олж харж байна. Үүний нэг нь Монгол Улсын Засгийн газраас гаргасан санаачилгыг хэрэгжүүлэх энэхүү эхлэл юм. Монгол Улсын орчин нөхцөлд Монголын хувийн хэвшлүүдийн дунд хүний эрхийн үйл ажиллагааны чухал талбаруудын тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх нь маш чухал хэвээр байсаар байна.

Олон сайн танилцуулга, ялангуяа ЖДҮ-ийн тухайд маш чухал яриа хэлэлцээрүүд их байдаг ч томоохон компаниудын хувьд оролцооны бодит үр өгөөж, баримтлал хоёрыг хоёуланг нь харах шаардлагатай байна. Нэгдүгээрт энэ ойлголт нь чухам юуны тухай болохыг ойлгох, мөн боломжит болоод сөрөг нөлөөллүүдийг аль алиныг нь ойлгох шаардлагатай байна. Тиймээс бид энхүү санаачилгыг эхлүүлж байгаадаа, үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн нэг хэсэг нь болж байгаадаа маш их баяртай байна.

Миний хувьд Монголын компаниудын тухайд нэр хүндийн эрсдэлийн асуудал гэж үзэж байна. Ялангуяа хэрэв Монгол компаниуд зөвхөн Европ ч гэлтгүй хаа ч тэр экспортод бүтээгдэхүүнээ гаргах гэж байгаа бол нэр хүндээ өсгөх шаардлагатай. Хуулийн боломжит эрсдэл миний бодлоор их доогуур байна. Нэг талаасаа компаниуд бие биенээсээ суралцах тал дээр эерэг жишээ болж чадна гэж бид итгэдэг. Тухайлбал Европ, Монголын аж үйлдвэрийн танхимууд гишүүн орнуудынхаа эсвэл Европын болон бусад эх компаниудынхаа сайн жишээнээс танилцуулж тэдгээрийг Монголын компаниудтай шууд холбож болох юм.

Бид Худалдаа аж үйлдвэрийн танхимтай ойрын хүрээнд ажилладаг. Практикал байх нь маш чухал. Мөн Монголын орчин нөхцөлд бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн асуудлууд маш чухал юм. Хүүхдийн хөдөлмөр болон бусад асуудлын тухай сонсогддог. Би Монголд ирээд 7 жил гаруй болж байна. Тиймээс Монгол ерөнхийдөө сайн байгаа гэж хэлж болно. Тиймээс бид үргэлж ахиулах боломжтой. Мөн бизнес хүний эрхтэй холбогдож болохуйц өөр ямар талбарууд байна гэдгийг харах хэрэгтэй. Тэдгээрийн хоёрыг нь бид харж байна.

Нэгдүгээрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талбар мөн. Энэ асуудал дээр бид уул уурхайн тухай ярьж болно. Тухайлбал уул уурхайн үйл ажиллагааны дараа газрыг нээгээд орхидог тэдгээрийн нөхөн сэргээлт, аюул хор хохирлын тухай бид ярьж болно. Энэ бол маш чухал асуудал.

Дараагийнх нь мал аж ахуй, цөлжилттэй холбоотой асуудлыг гаргаж ирэх нь чухал. Энэ бол Монголтой, ялангуяа Монгол дахь бизнес эрхлэлттэй холбоотой чухал талбар юм.



Тиймээс энэ үзэл бодлын хувьд Европын хамгийн сайн нөү-хау-г оруулж ирэхдээ бид туйлын баяртай байх болно. Ялангуяа уул уурхайн үйл ажиллагааны дараа газрыг нөхөн сэргээх асуудал дээр бид нөү-хау нэвтрүүлэх боломжтой. Бидэнд төв Европын улс орнуудын тухайлбал Польш, Герман, Бельги, миний өөрийн Чех улсуудын туршлага байна. Сүүлийн хэдэн арван жилийн туршлага байна.





Энд хүрээд би зогсоё. Энд илүү дотоодын шинж чанартай өөр нэг талбар байна. Хамгийн сүүлийн үеийн EUGSU-ний үндэслэл, 2018, 2019 оны хяналтын тайлан, мөн ОУХБ-ын үргэлжилсэн судалгааны үр дүнг ажиглаж байхад албан бус ажил эрхлэлт Монгол улсын нийт ажил эрхлэлтийн 50% гэж гарч байна. Тэгвэл үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө ажилгүйдлийн ийм өндөр түвшинтэй холбоотой эрсдэлүүдэд ямар арга хэмжээ авах вэ, үүнийг яаж харах вэ? Мөн ажилчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хамгаалалт ийм доогуур байгаад ямар арга хэмжээ авах вэ? О.Амартүвшин даргын дурьдсан КОВИД-19-тэй холбоотой ажилгүйдэл, орлогын дарамтыг яах вэ гэсэн асуудлууд тулгарч байна. Тиймээс бидний өмнө хийх ажил их байна. Тиймээс энэ чухал арга хэмжээг эхлүүлж байгаад би дахин дахин баяртай байна. Намайг энэ үнэтэй үйл ажиллагаанд оролцуулсанд баярлалаа. Зөвхөн өнөөдрийн үйл ажиллагаанд ч биш, ирээдүйд хийгдэх зүйлүүдийн төлөө би хувь нэмрээ оруулахад бэлэн байна.

Чиглүүлэгч В.Оюу: Сүүлийн панелист бол Мойлтмаа. Бизнес ба хүний эрхийн үндэсний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүн, хүний эрхийн хуульч Мойлтмаа өнөөдрийг хүртэлх бидний амжуулсан үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад нэн шаардлагатай нэг суурь ажил болох “Бизнес ба хүний эрхийн суурь үнэлгээ” гаргах ажлыг хариуцан ажиллаж байна. Эхний ээлжинд бид төслөө гаргаад байна.

- Сая Томаш Бравенекийн хэлсэн Монголд бизнес ба хүний эрхийн чиглэлээр тулгамдаж байгаа гол асуудлуудыг суурь үнэлгээгээр гаргах гэж хичээсэн. Тиймээс энэ талаар Мойлтмаагаас сонсоё.



С.МОЙЛТМАА

Бизнес ба хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн Гишүүн, хүний эрхийн Хуульч

Өдрийн мэнд.

Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын процессийн гол чухал ажил бол үндэсний суурь үнэлгээ буюу Монгол Улсад бизнес ба хүний эрхийн нөхцөл байдал ямар байгаа вэ? Монгол Улсад бизнес хүний эрхэд ямар сөрөг нөлөө үзүүлж байгаа вэ? Мөн эерэг ямар нөлөө үзүүлж байгаа вэ? гэдгийг тогтоох үндсэн гарааны шатан дээр манай улс явж байна.

Ажлын хэсгээс үндсэндээ тайланг одоогоор бэлдээд явж байна. Тайлан маань баримт бичгийн шинжилгээн дээр үндэслэсэн сүүлийн таван жилийн хугацаанд Монгол улсад хийгдсэн судалгаа шинжилгээний ажлууд мөн НҮБ-д явуулсан тайлангууд, статистик тоо баримтууд дээр үндэслэсэн суурь мэдээллүүдийг нэгтгэсэн. Тайланг холбогдох бүх талууд буюу бизнес, төр, иргэдийн болон бизнесийн нөлөөлөлд өртөж байгаа бүх иргэдийн бүлгүүдээр хэлэлцүүлж эцэслэнэ. Ковидын нөлөөллөөс болоод бүрэн хэлэлцүүлэг өрнүүлж, эцэслэж арай амжаагүй байна.



МОНГОЛ УЛСЫН
ГАДААДХАРИЛЦААНЫЯАМ



БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ НЬ ГУРВАН ТУЛГУУРТАЙ

Тайлангийн хамрах хүрээ нь бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд буюу үндсэн гурван зарчмыг дэвшүүлж хамрах хүрээг авч үздэг.



Хүний эрхийг хамгаалах төрийн үүрэг, хүний эрхийг хүндэтгэх бизнесүүдийн үүрэг, мөн хохирсон, зөрчигдсөн эрхийг сэргээх гэсэн үндсэн хүрээнд манай улсын нөхцөл байдал ямар байна вэ гэдгийг баримт бичгийн шинжилгээнд үндэслэж хийсэн.



Хүний эрхийг хамгаалах төрийн үүрэгт Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенцуудыг авч үздэг. Манай улс энэ чиглэлд бусад орнуудтай харьцуулахад нэлээн манлайлж явдаг. Хүний эрхийн суурь гол конвенцуудад нэгдэж орсон байд-гаас гадна тэдгээрийг үндэсний хууль тогтоомжид тусгаад явж байна. Гэхдээ мэдээж бизнесээс хүний эрхэд учруулж болохгүй, бизнесүүдэд үүргийг нь оноосон яг хуулийн зүйл заалт бол манай улсад харахан бүрэлдээгүй байна гэж хэлж болохоор байна. Түрүүнд хэлсэн Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль гэх мэт суурь эрхүүдийг бизнесүүдэд үүрэг болгож оноосон бүтэн хуулиуд байдаг. Гэвч эргээд бид нар Компанийн тухай хууль, Татварын тухай хууль гэх мэт бизнесийн үндсэн үйл ажиллагааг тогтмол зохицуулж байгаа энэ хуулиудыг эргээд харахад хүний эрхийг хангаагүй бол ийм хэмжээний шийтгэл хүлээнэ гэсэн зүйл заалт одоогоор манайд дутагдалтай байгаа нь харагдаж байна.

Бизнесүүдээс хүний эрхийг хамгаалахдаа ямар хэмжээнд байна вэ гэдэг дээр манай улсад хийсэн суурь судалгаа, статистик, тоо баримт маш ховор байна. Нийт компанийн хэдэн хувь нь хүний эрхийг хангах тал дээр бодлого гаргаж, дотоод дүрэм журамдаа тусгаад явж байгаа тухай бүрэн зураглал гаргасан судалгаа маш хомс байна.

Тиймээс ийм хэрэгцээ шаардлага бий. Магадгүй энэ төслийн хүрээнд энэ тоо баримт цаашид тодорхой гарах байх. Ер нь хөдөлмөрлөх эрхийг бизнесийн байгууллагууд хэрхэн хангаж байна вэ гэдгийг тус тусад нь сэдэв сэдвээр нь нарийвчилж авч үзсэн тайлангууд бол нэлээн байна. Ялангуяа ялгаварлан гадуурхалтай холбоотой, эрэгтэй эмэгтэй ажилтнуудын цалингийн зөрүү, эмэгтэй ажилтнууд үнэхээр ялгаварлан гадуурхалгүйгээр бизнесийн ямар нэг үйл ажиллагаанд оролцож чадаж байна уу, чадахгүй байна уу? Мөн ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой судалгааны ажлууд, тоо баримтууд байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрлөх эрхээр хангаж байгаа байдал ямар байна вэ гэдэг дээр судалгаа шинжилгээний ажлууд хийгдэж байна. Гэхдээ манай судалгаануудыг авч үзэхэд төр, хувийн хэвшил хоёрыг ялгаж судалгааны үр дүн гаргасан байдлууд маш хомс байна.

Нийтлэг үр дүнгүүд байгаа боловч тэдгээрийн хэд нь хувийн хэвшлээс гарч байгаа зөрчил вэ? Хэд нь төрийн байгууллага дээр гарч байгаа вэ гэдгийг ялгаж салгаж харахад хүндрэлтэй тоо баримтууд бол нэлээн бий. Албадан хөдөлмөр тэр дундаа хүүхдийн хөдөлмөр манай улсад нэлээдгүй байна гэж гарсан байдаг. Статистикийн үндэсний хорооноос гаргасан тоо баримтуудаас харахад 5-17 насны 10 хүүхэд тутмын 1 нь үндсэндээ хөдөлмөрийн харилцаанд орж байна гэсэн тоо баримт бий. Гэвч эргээд энэ нь бизнесийн аль аль салбарт байгаа вэ? Ямар үндсэн шалтгаантай вэ гэдгийг дэлгэрэнгүй харуулсан тоо баримт бас маш хомс байна. Мөн эвлэлдэн нэгдэх эрх дээр ч мөн адил байна. Эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэж чадахгүй байгаа хувь хэмжээ манай улсад нэлээд өндөр гардаг.

Гэвч эргээд төрийн өмчийн компаниуд дээр илүү байна уу? Хувийн хэвшил дээр байгаа юм уу? Том жижиг яг ямар салбар дээр байгааг нарийвчилж харуулсан тоо баримт бас л хомс байна. Хамгийн гол нь Монгол Улсад үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлах зөвлөмжийг өгч байгаа улс орнууд бол зөвлөмжийн гол нарийвчилсан мэдээлэл дээр малчдын эрх ашиг, малчид хүний эрхийн суурь боломжоо эдлэх эрхийг тусгайлан авч үзэхийг Монгол Улсын засгийг газраас шаарддаг.

Суурь үнэлгээний нэг хэсэг маань малчид томоохон уул уурхай болон бусад дэд бүтцийн төслүүдийн нөлөөлөлд өртөж байгаа гэдэг субъектийн зүгээс, нөгөө талаас малчин иргэд маань өөрсдөө хөдөлмөрийн харилцаанд маш их оролцож байгаа ажилтан гэдэг талаас нь авч үзэхийг зорьсон. Яагаад гэвэл малчид хөдөө аж ахуйн маш олон бүтээгдэхүүний хангамжийн сүлжээний хамгийн чухал оролцогч байдаг. Энэ үүднээс малчид ямар байдалтай эрхээ эдлэж байна вэ гэдэг дээр судалгаа хийж байна. Сүүлийн үед ХЭҮК болон Европын Холбооны зарим төслүүдээс нэлээн анхаарал хандуулж, судалгаа тоо баримтуудыг цуглуулж тайлагнаад явж байна.

ТУЛГУУР ЗАРЧИМ 1



Төр нь хүний эрхийг хамгаалах, зөрчигдөхөөс сэргийлэх, хууль тогтоомжийг батлах төдийгүй хэрэгжүүлэх үүрэгтэй.



- Төрөөс хүний эрхийг хамгаалах хэм хэмжээг тогтоох төдийгүй өөрийн оролцоотой бизнесийн үйл ажиллагаанд ч хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх үүрэгтэй.

ТУЛГУУР ЗАРЧИМ 2

Компани нь хаана ч, ямар ч бизнесийн үйл ажиллагаа эрхэлсэн хүний эрхийг зөрчихгүй байх үүрэгтэй.



- Энэ нь зөвхөн хууль тогтоомжийг мөрдөх эсхүл цөөн ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаанд нь аудит хийлгэснээр дуусгавар болох ёсгүй.
- Компаниуд төрийн оролцоогүйгээр өөрсдөөсөө шалтгаалах хүний эрхийн нөлөөг илрүүлж, түүнийг сайжруулах бодит алхам хэрэгжүүлэх үүрэгтэй.

ТУЛГУУР ЗАРЧИМ 3

Хүний эрхийн зөрчлийг хэрхэн шийдвэрлэх үр дүнтэй механизмыг тодорхойлдог.

ТӨР



КОМПАНИ



- Компани хүний эрхийг зөрчсөн бол хохирогч гомдол гаргаж, тухайн гомдлыг хянан шалгаж, шийдвэрлэх хууль, шүүхийн тогтолцоо, хууль ёсны механизмыг бүрдүүлэх
- Хүний эрхийг баталгаажуулах хүрээнд компанийн үйл ажиллагаанаас хүний эрхийн нөлөөлөлд өртсөн иргэдийн гомдол гаргах боломжоор хангаж, түүнийг шийдвэрлэж, зөрчлийн арилгах үйл явцад оролцох.



БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ ХӨТӨЛБӨР

Хамгийн сүүлд зөрчигдсөн эрх сэргээх механизм явдаг. Үүн дээр бизнес ба хүний эрхтэй холбоотой ямар асуудал дэвшүүлдэг вэ гэхээр зөрчигдсөн эрхийг аливаа бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх зөрчигдлөө гэхэд түүнийг шүүхийн механизмаар шийддэг. Энэ бол уламжлалт арга.

Өөрөөр удирдах зарчим дээр бол улс орнуудад юу санал болгодог вэ гэхээр шүүхийн бус аргаар төрийн оролцоогүй хувийн хэвшил өөрийн дотоод механизмаар болон бусад арга замуудаар зөрчигдсөн эрхийг сэргээх хууль эрх зүйн хүрээнд оновчтой тодорхойлооч хэмээн санал болгодог. Энэ тал дээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулалтын томоохон банкууд, хөрөнгө оруулагч нар шүүх, төрөөс хараат бус өөрсдийн гэсэн механизмтай байдаг. Үүнийг ашиглаж ялангуяа томоохон хөрөнгө оруулалт дээр, дэд бүтэц болон уул уурхайн төслөөс үүдэлтэй эрх нь зөрчигдөж байгаа иргэдийн эрхээ сэргээх боломжуудыг олон улсад бүрдүүлж өгсөн байдаг. Манай улсад бол тодорхой элементүүд ороод ирсэн. Гэхдээ үүнийг улам бүр боловсронгуй болгох, улам тодорхой болгох, заавал том байгууллага гэлтгүй ямар нэгэн хэмжээгээр хүний эрхтэй холбогдож байгаа, хүний эрхийг хөндөх боломжтой бизнесүүд бол бүгд өөрийн гэсэн дотоод хүний эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, барагдуулах боломжуудыг бүрдүүлэхийг удирдах зарчмаар санал болгодог. Цаашид манай улсад үүнийг зохицуулсан хууль, эрх зүйн орчин хэрэгцээтэй байгаа нь үндэсний суурь үнэлгээгээр гарсан.

Чиглүүлэгч В.Оюу: Бидэнд олгогдсон 50 минут үүгээр дуусч байна. Панелд оролцсон бүх панелистуудад маш их баярлалаа. Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажилд бүх талаараа хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

Зохион байгуулагч: Маш сонирхолтой олон чухал асуудлуудыг хөндөн ярилцсан чиглүүлэгч болон оролцогч та бүхэнд баярлалаа.



Хурал зохион байгуулагч: Одоо хөтөлбөрийн дагуу бизнесийн байгууллагуудад зориулсан хүний эрхийн менежментийн арга хэрэгсэл, мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийн товч танилцуулах хэсэг эхэлж байна. Танилцуулгыг эхлүүлнэ үү хэмээн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Төслийн зохицуулагч Р.Ариунбилэг таныг урьж байна.

Хүний эрхийн менежментийн арга хэрэгсэл, мэдлэгийн бүтээгдэхүүнүүд



Р.АРИУНБИЛЭГ

НҮБХХ-ийн Бизнес ба
Хүний Эрхийн
Төслийн зохицуулагч

Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр бизнес ба хүний эрхийн зарчмуудын талаар ярьж байна. Энэхүү зарчмуудыг амьдрал практикт яаж хэрэгжүүлэх вэ гэдэг талаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр ялангуяа энэ төслийн хүрээнд анхаарч ажиллахаар төлөвлөж байна. Та бүхэнд энэ хөтөлбөрийн хүрээнд гарсан сүүлийн үеийн хэд хэдэн мэдлэгийн бүтээгдэхүүн, хүний эрхийн зарчмыг амьдрал практикт хэрэглэх менежментийн түүл гэж нэрлэгддэг арга хэрэгслүүдээс танилцуулъя.

Сая оролцогчид маань дурьдсан Бизнес ба Хүний эрхийн Азийн бүсийн хөтөлбөр Монгол Улсад ямар үндсэн чиглэлээр чиглэж ажиллах вэ гэвэл эхний ээлжинд НҮБХХ-өөс бизнес ба хүний эрхийн үндэсний үйл ажиллагаа боловсруулах Засгийн газар дээр өрнөж байгаа үйл ажиллагааг дэмжих, боловсруулах чиглэлд ажиллана.

Мөн оролцогч талууд Засгийн газар, бизнесийн байгууллагууд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд гэх мэт байгууллагуудын мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, мэдлэгийн бүтээгдэхүүн менежментийн арга хэрэгслүүдийг боловсруулж гаргаж өгөх гэсэн энэ чиглэлээр ажиллана.

Иргэний нийгэм, олон нийтийн оролцоог дэмжих чиглэлээр ажиллана. Төр, бизнес, олон нийтийн үр дүнтэй хамтын ажиллагааны бизнесийг бэхжүүлэх дэмжих чиглэлээр төсөл маань чиглэж ажиллана. Түүнчлэн ЕХ-оос Монгол Улсад хэрэгжүүлж байгаа эдийн засаг, бизнесийг дэмжих бодлого, хөтөлбөр үйл ажиллагаатай уялдаж ажиллахаар төлөвлөсөн байгаа. Энэ ажлын хүрээнд бид НҮБХХ-өөс хэд хэдэн бүтээгдэхүүн гаргасан. Түүнчлэн яг одоогийн байдлаар иргэний нийгэм, олон нийтийн оролцоог дэмжих чиглэлээр иргэний нийгмийн тэтгэлэгт хөтөлбөр зарлаад байна. Энэхүү тэтгэлэгт хөтөлбөр тавдугаар сарын 7-ны өдрийг хүртэл төслөө авч байна. Тэтгэлэгт хөтөлбөрийн линкийг оруулж өгсөн. Энэ линкрүү хандаад иргэний нийгмийн байгууллагууд нь бизнесийн байгууллагуудтай хамтраад бизнес ба хүний эрхийн жижиг төслийн уралдаанд оролцох боломжтой юм.

2020-2021 онд гаргасан мэдлэгийн шинэ бүтээгдэхүүнийг танилцуулъя. Үүнд:

- НҮБ-ын бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд Монгол хэл дээр гарсан байгаа. Үүнийг орчуулж хэвлэж тараасан. Дээрээс нь НҮБ-ын www.undp.org сайт дээр онлайн хувилбараар оруулсан.
- Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний гарын авлагыг 2021 онд ХЭҮК-той хамтран боловсруулж гаргасан. Төрөл бүрийн төслүүдэд хүний эрхийн үнэлгээг хийх гарын авлага, аргачлал манай улсад байдаггүй байсан. Энэ оноос гарын авлагатай боллоо. Үүнийг бас энэ линкээр орж татаж авч үзэж үйл ажиллагаандаа ашиглах боломжтой.
- Хүний эрхийн магадлан шинжилгээ ба Ковид-19 гэдэг цар тахлын үед бизнесийн байгууллагууд өөрийнхөө хүний эрхэд үзүүлж байгаа нөлөөгөө үнэлэх, өөрийгөө үнэлэх түргэвчилсэн тест гэдэг гарын авлагыг саяхан Монгол хэл дээр гаргасан байна. Энэ гарын авлага бизнес ба хүний эрхийн Азийн хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдаж, Азийн 12 орны хэл дээр орчуулагдаж, Азийн бизнесийн байгууллагуудад хэрэглэгдэж эхэлсэн. Үүний линкийг бас оруулсан. Татаж авч энэ цар тахлын үед өөрийнхөө үнэлгээг хийж болно.

Манай улсын хэмжээнд бизнес ба хүний эрхийн асуудал бол шинэлэг асуудал. Хаана хаанаа мэдлэг, мэдээлэл хомс байгаа. Тиймээс энэ чиглэлээр бизнесийн байгууллага, төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд төрөл бүрийн сургалт, судалгааны арга хэмжээг явуулах шаардлагатай байгаа юм. Энэ сургалтын арга хэмжээнд эдгээр мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг ашиглах бүрэн боломжтой.

- Монгол хэл дээр бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын тухай 4 цуврал богино хэмжээний видеог бид дохионы хэлтэйгээр гаргасан. Энэ видеонуудыг линкээр орж татаж авч өөрсдийн үйл ажиллагаа, өөрийн байгууллага дээр сургалт зохион байгуулахдаа, бизнес хүний эрхийн зарчмыг судалж хэрэгжүүлэхдээ ашиглах бүрэн боломжтой.

1. Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн зөрчлийн талаарх гомдол шийдвэрлүүлэх эрх:

<https://www.youtube.com/watch?v=sUT-StY9GHk>

2. Бизнес ба Хүний эрхийн Үндэсний Үйл Ажиллагааны Төлөвлөгөө

<https://www.youtube.com/watch?v=Zg3mxxuv3pM>

3. Хүний эрхийг магадлан нягтлах ажиллагаа - Бизнес ба Хүний эрх:

<https://www.youtube.com/watch?v=MqyazLjtnTI>

4. НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн Удирдах Зарчмууд - Танилцуулга:

<https://www.youtube.com/watch?v=agJstrl2ZDE&t=34s>

Тиймээс энэ линкүүдыг энэхүү хурлын чат дээр байршуулна. Мөн НҮБХХ-ийн вэб сайт руу орж ашиглах боломжтой.

Одоо, 2018 оноос хойш НҮБХХ Хүний эрхийн үндэсний комисстой хамтран боловсруулсан хүний эрхэд нөлөөлөх байдлын гарын авлагын талаар Хүний эрхийн үндэсний комиссын дарга, тамгын газрын дарга Ч.Алтангэрэлийг товч танилцуулна уу хэмээн урьж байна.

Энэхүү гарын авлага Таван толгойн нүүрсний бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны жишээн дээр боловсруулагдсан.



Хүний Эрхэд Нөлөөлөх Байдлын Үнэлгээний гарын авлага: Таван Толгойн Бүлэг Орднн жишээ



Ч.АЛТАНГЭРЭЛ

Үндэсний Комиссын
Тамгын Газрын Дарга

Нийт арга хэмжээнд оролцогч нартаа энэ өдрийн мэнд хүргэе. Бид хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ гэж юу вэ? Энэ нь чухам яагаад Монгол Улсад хэрэгтэй вэ? гэдгийг товч танилцуулъя гэж бодож байна.

Хүний эрхэнд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэг нь аливаа томоохон бизнесийн болоод дэд бүтцийн төслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох хүний эрхийн сөрөг нөлөөллүүдийг олж урьдчилан тогтоох, түүнийг бууруулах, илрүүлэх, тодорхой арга хэмжээ авах замаар илүү сайн үр дүнд чиглэсэн, хамтын оролцоонд тулгуурласан шинэлэг арга хэмжээ юм. Энэ нь зөвхөн Монгол Улсад төдийгүй дэлхий нийтэд нилээн шинэлэг үнэлгээний арга хэрэгсэлд тооцогддог. ХЭҮК-ын зүгээс 2016 оноос хойш хүний эрхийн нөхцөл байдлын нөлөөллийн үнэлгээг Монгол Улсад хэрэгжүүлэх, ингэснээрээ бизнесийн болоод томоохон дэд бүтцийн төслүүд хэрэгжүүлвэл илүү их амжилттай үр дүнтэй болох юм байна гэж зорьсон.

Сая Р.Ариунбилэг зохицуулагчийн танилцуулсан НҮБХХ болоод Шведийн байгаль орчны агентлаг хоёрын хамтран хэрэгжүүлсэн байгаль орчны зохицуулагчдын хүрээнд уул уурхайн төслүүд дээр жишиг болгож хийж үзсэн. Үүнийг 2018 оны 3-р сараас 11-р сар хүртэлх хугацаанд хийсэн. Таван толгойн бүлэг ордны нүүрс олборлох болон тээвэрлэх үйл ажиллагаанд хийсэн хүний эрхийн нөхцөл байдлын үнэлгээ юм.





Ер нь аливаа томоохон төсөл олон тооны хүний эрхийн эерэг болон сөрөг асуудлуудыг хөнддөг. Гэхдээ үүнийг тухайн төслийг хэрэгжүүлэгч нь нуун дарагдуулснаар шийдвэрлэж чадахгүй. Тиймээс тухайн төслийн үр дүнд гарах, хөндөгдөж болох хүний эрхийн асуудлуудыг эртнээс тодорхойлж, оролцогч талуудтай зөвшилцөх аргуудыг хэрэглэснээрээ илүү их үр дүнтэйгээр тухайн төслийг хэрэгжүүлэх нийгмийн зөвшөөрлөө авч чадах юм гэсэн үзэл санаа нь хүний эрхийн нөхцөл байдлын үнэлгээний гол арга хэрэгслүүр юм.



Таван толгойн бүлэг ордны нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүрээнд хийсэн үнэлгээгээр нийт дөрвөн бүлэг асуудлыг авч үзсэн.

- 1. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт** буюу агаар, хөрс, усны бохирдол, тоосжилтын асуудал гэсэн томоохон бүлэг байгаа.
- 2. Нийгмийн суурь үйлчилгээг авах, үйлчилгээний чанар хүртээмж**
Цогт-цэций сумын төвийн жишээн дээр тулгуурлаж хөдөлгөөнт хүн ам ихэссэн байгаа энэ тохиолдолд нийгмийн суурь үйлчилгээг авах, тэр үйлчилгээний чанар хүртээмжийн асуудал ямар байна вэ? гэдэг асуудлыг судалж гаргаж ирсэн.
- 3. Нүүрс тээврийн үйл ажиллагаа.** Энэ бол уурхайн ам буюу таван толгойн бүлэг ордоос БНХАУ-ын Ганц модны боомт хүртэлх нийт 14000 гаруй тээврийн хэрэгсэл, түүний жолооч нар оролцдог нилээн өргөн хүрээний маш их асуудал дагуулсан зүйл байдаг. Жолооч нарын хөдөлмөр эрхлэлтийн байдал, тэр дундаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, цалин хөлс, эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын асуудлуудыг авч үзсэн.
- 4. Соёлын эрх** буюу Монгол Улсын говийн нутгаар амьдарч байгаа малчин иргэдийн нүүдлийн мал аж ахуйг эрхлэх соёлын асуудлыг авч үзсэн томоохон бүлэг болсон.

Ингээд 2018 онд олон талыг оролцуулсан үнэлгээний зөвлөмжийг хоёр удаа танилцуулж, нийтдээ долоон бүлэг асуудлаар 42 зөвлөмж гаргаж Монгол Улсын Засгийн газраас эхлээд орон нутгийн засаг захиргаа, уул уурхайн компаниуд болон бусад эрх бүхий байгууллагуудад хүргүүлснээр нилээн амжилттай үр дүнд хүрсэн. Цаашлаад Таван толгойн бүлгийн нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэнд нөлөөлөх нөхцөл байдлын үнэлгээг хийхэд нилээн олон хамтарсан ажлын хэсэг гарч ажиллах ёстой гэж үзэн 2 жил гаруй хугацаа өнгөрсөн. Үүний дараа буюу 2020 оны 10-р сард тухайн зөвлөмжийн хэрэгжилт ямар байгаа вэ? гэдгийг бид холбогдох төрийн яамд, Хүний эрхийн үндэсний комиссын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж зөвлөмжийн хэрэгжилтийг гаргасан.

Хоёр жилийн турш хийсэн ажлын үр дүнд бид хүний эрхэд нөлөөлөх байдлын гарын авлагыг гурван бүрэлдэхүүн хэсэг байдлаар боловсруулж хэвлүүлсэн. Энэ бол нэгдүгээрт хүний эрхэнд нөлөөлөх нөхцөл байдлын аргачлалаа хэрхэн хийх вэ? гэдгийг түрүүнд дурьдсан бодит жишээн дээр үндэслэж үнэлгээг анх хийж, бодлого инновацийн хүрээлэнтэй хамтран хийсэн. Хоёрдугаарт таван толгойн бүлэг ордод хийсэн хүний эрхэнд нөлөөлөх нөхцөл байдлын үнэлгээний тайланг бүрэн эхээр нь оруулсан байгаа. Гуравдугаарт 2020 онд хийсэн хүний эрхэнд нөлөөлөх нөхцөл байдлын үнэлгээний зөвлөмж ямар байдлаар хийгдсэн бэ? Ямар үр дүн гарсан бэ? гэдгийг 2 жилийн дараа нэгтгэж тайланг гаргасан юм.

Үүнээс харахад бүх талын оролцогчдод бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийн асуудал маш чухал гэдэг ойлголтыг өгөхөд чиглэсэн. Аливаа бизнесийн төсөл эхлэх, төлөвлөхөөсөө эхлээд тэр дундаа уул уурхай, дэд бүтцийн хүрээнд хамрах цар хүрээ нь өргөн төсөл бол хүний эрхийг ямар нэг байдлаар хөндөх нь тодорхой. Тиймээс хүний эрхийн асуудлыг байгаль орчны, нийгмийн нөлөөлөл гэдгээс нь хамааруулан хүний эрхийн асуудлыг хөндөхгүй орхих боломжгүй болсон. Энэ хүрээнд оролцогч талуудын оролцоо, сонирхол өндөр болсон байна. Тиймээс аль болох гарч болох сөрөг нөлөөллийг эртнээс тооцож шийдвэрлэх арга замуудаа бүх оролцогч талуудтай зөвшилцөж шийдвэрлэх хэрэгтэй. Мөн эерэг сайн үр дүнг эхнээс нь тодотгож, илүү тогтворжуулж авч явах ёстой. Энэ нь нөгөө талаасаа томоохон төслүүдийн санхүүжилтийн гол шалгуур, шаардлага болоод байна. Тиймээс ХЭҮК-ын зүгээс хүний эрхэнд нөлөөлөх нөхцөл байдлын үнэлгээ гэдэг зүйлийг Монгол Улсын хэмжээнд нэвтрүүлье. Цаашид Монгол Улсын хэмжээнд өргөн хүрээтэй хэрэглэж, ашигладаг байгаасай гэсний үндсэн дээр энэ гарын авлагыг боловсруулан гаргасан. Ялангуяа бизнесийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаанд энэ гарын авлагыг ашиглаад тодорхой үнэлгээ хийгээсэй гэж уриалж байна. Мөн ХЭҮК-ын зүгээс энэ асуудлыг дэмжиж ажиллах болно.

Р.Ариунбилэг: Алтангэрэл даргад баярлалаа. Одоо “Хүний эрхийн магадлан шинжилгээ ба Ковид-19” бизнесийн байгууллага өөрийгөө үнэлэх түргэвчилсэн төстийн талаар товч танилцуулна уу? хэмээн НҮБХХ-ийн төслийн зөвлөх Мандхайг урьж байна.

Хүний Эрхийн Хянан Магадлагаа: Ковид-19 цар тахлын үед бизнесийн байгууллага өөрийгөө үнэлэх түргэвчилсэн тест



М.МАНДХАЙ

НҮБХХ-ийн
Бизнес ба Хүний
Эрхийн Төслийн
Зөвлөх

Өдрийн мэнд хүргэе.

“Хүний эрхийн магадлан шинжилгээ ба Ковид-19” бизнесийн байгууллагын өөрийгөө үнэлэх түргэвчилсэн тестийг 2020 оны 4-р сард НҮБХХ-өөс боловсруулан гаргасан. Энэ нь бизнесийн байгууллага өөрийгөө үнэлэх түргэвчилсэн тестийн шинэчилсэн дэлгэрүүлсэн хувилбар юм. НҮБ-ын гэрээ конвенцууд болон олон улсын хөдөлмөрийн байгууллагуудын суурь конвенцуудын холбогдох заалтууд, НҮБ-ын Хүүхдийн сангийн удирдамж мөн НҮБ-ын Хүний эрхийн үндсэн зарчмуудад суурилан боловсруулагдсан үнэлгээ юм. Ковид-19 цар тахлаас үүдэлтэй дэлхий нийтийг хамарсан нийгэм-эдийн засгийн хямрал бол тэгш бус байдал, улс төрийн тогтворгүй байдал, экологийн эмзэгшил зэрэг олон сөрөг нөлөөг үүсгэж байна. Бизнесийн хувьд бол бизнесийн байгууллагууд түүхий эдээс эхлээд үйлдвэрлэл үйлчилгээ, борлуулалт, ажилчдын тогтвортой байдлыг хангах мөн ханган нийлүүлэлтийн бүхий л сүлжээнд маш их сорилт бэрхшээлүүдтэй тулгардаг.

“

Иймээс бизнесийн үйл ажиллагаанаас шалтгаалан хүний эрхэнд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, түүнийг зохистой шийдвэрлэх зорилго бүхий зургаан бүлэгтэй 51 асуултаас бүрдсэн түргэвчилсэн тестийг боловсруулаад байна.

”

Үндсэн 6 агуулга бол хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, хөдөлмөрлөх эрх, байгаль орчин иргэдэд үзүүлэх нөлөө, хувийн нууцыг хамгаалах, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, компанийн бодлого менежмент гэсэн 6 бүлгээс бүрдсэн.

Бид компаниудаас өөрийгөө үнэлэх тест авсан. Тус судалгааг авахдаа салбарын хувьд төрөлжсөн мөн компанийн бүтэц хэлбэрийн хувьд жижиг дунд том компаниудыг үнэлгээндээ хамруулахаар зорьсон. Мэдээж олон компаниуд тус үнэлгээг хийх хэрээр үр дүн өөрчлөгдөхийг үгүйсгэхгүй. Туршилтын судалгаа бол мэдлэг, мэдээлэл түгээх зорилготой судалгаа юм. Тиймээс албан ёсны биш тест маягаар авсан судалгаа гэж ойлгож болно.


Энэхүү үнэлгээг ерөнхийд нь товч танилцуулахад нийт 6 компанийн үнэлгээг авч үзэхэд үндсэндээ 58 асуулт нь шаардлага хангасан тийм буюу энэ шаардлагыг хангаж байна, манайд энэ бодлого хөтөлбөр байдаг, хүний эрхийг зөрчихөөс сэргийлж ажилладаг гэсэн дундаж нь 80 хувьтай гарсан. Гэхдээ мэдээж хангалтгүй үзүүлэлт байсан. Үүн дээр анхаарал татахуйц 4 бүлэг байна.

1. Компанийн бодлого менежмент 73 хувьтай
2. Байгаль орчин иргэдэд үзүүлэх нөлөө 75 хувьтай
3. Хувийн нууцлалыг хамгаалах 78 хувьтай
4. Гутаан доромжлох ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх 80 хувьтай гарсан.

Үүнээс бизнесийнхэнд илүү сонирхуулбал компанийн бодлого менежменттэй холбоотой, хангалтгүй үзүүлэлттэй гурван анхаарал татахуйц асуудал байсан.

Үүнд: Ковид 19-ийн эсрэг Засгийн газрын урамшууллын бодлогод нийцүүлэн жижиг, дунд ханган нийлүүлэгчид болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийн амьдрах чадварыг нэмэгдүүлэхийн тулд төлбөрийг нь цаг тухайд нь төлөх, зээлийн хугацааг нь сунгах зэргийг дэмжих. Компанийн хүний эрхэнд тусгасан үүрэг хариуцлагын талаар дотоод болон гадаад оролцогч талуудад мэдээлэх. Ковид-19 цар тахалтай холбоотой хүний эрхийн сөрөг нөлөөллийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах, хариуцлага тооцохын тулд хүний эрхийн магадлан шинжилгээг хийх зэрэг асуулгад хангалтгүй гэсэн хариултаудыг бизнесийнхэн өгсөн.

Мэдээж энэ түргэвчилсэн үнэлгээ бол НҮБ-ын Хүний эрхийн удирдах зарчмуудад заасан хүний эрхийн магадлан шинжилгээ хийх бүрэн хэмжээний арга хэрэгсэл биш. Гэхдээ төрөл бүрийн салбарт нийтлэг тохиолддог хүний эрхийн эрсдэл ба нөлөөллийг тодорхой түвшинд хамруулан тусгасан түргэвчилсэн болон тасралтгүй үйл явцаар хүний эрхийг магадлан шинжилсэн арга хэрэгсэл болох боломжтой гэж үзэж байна.



Дүгнээд хэлэхэд энэхүү хүний эрхийн магадлан шинжилгээний агуулга хүний эрх ба бизнесийн баримтлах зарчмууд болон үндэсний суурь судалгааны үр дүнтэй холбоотой сургалтуудыг бид ажлын хэсгийн хүрээнд бизнесүүдтэй компаниудтай тусгайлан зохион байгуулна. Ингэснээр энэ магадлан шинжилгээ гэдэг нь юу юм бэ? Ямар агуулгын хүрээнд магадлан шинжилгээг бизнесүүд анхаарч хийх ёстой вэ? Ямар асуудлууд, ямар агуулгууд өөрөө тухайн бизнесийн үйл ажиллагаанаас хамаарсан хүний эрхийг зөрчиж байгаа юм бэ? гэдэг талаар мэдлэг, мэдээллийг түгээх сургалтуудыг бид ойрын хугацаанд зохион байгуулахаар төлөвлөж байна. Бизнесийн сургалтуудад компани идэвхтэй оролцож олон улсын бизнесийн зарчмууд болон чиг хандлагатай хөл нийлүүлэн алхана гэдэгт итгэж байна. Баярлалаа. Баярлалаа.

Р.Ариунбилэг: Мандхайд баярлалаа. Ингээд НҮБХХ-өөс гаргасан эдгээр мэдлэгийн бүтээгдэхүүнийг та бүхэн үйл ажиллагаандаа ашиглаарай. Дараагийн шатны сургалт, мэдээлэл түгээх ажилд та бүхнийг өргөнөөр оролцохыг урьж байна. Баярлалаа.

Хурал зохион байгуулагч: Маш сонирхолтой хэрэгцээтэй бүтээгдэхүүнүүдийг танилцуулсан та бүхэнд баярлалаа.

Хурал зохион байгуулагч:

Ингээд энэхүү арга хэмжээний дараагийн хэлэлцүүлэг эхлэхэд бэлэн болоод байна. Дотоодын болон олон улсын бизнесийн байгууллагуудын манлайлагчдаас бүрдсэн энэхүү хэлэлцүүлэг маань “Бизнес ба хүний эрх онолоос практикт” сэдвийн хүрээнд өрнөнө. Олон улсын эмэгтэйчүүдийн худалдаа аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч ба Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэд ерөнхийлөгч О.Байгаль энэхүү хэлэлцүүлгийг удирдан чиглүүлнэ. Хэлэлцүүлэгт оролцох зочдоо товч танилцуулбал:

- Саух round table” бизнесийн манлайлал олон улсын сүлжээ байгууллагуудын Япон дахь салбарын гүйцэтгэх захирал Хироши Ишида,
- Монос группын гүйцэтгэх захирал Х.Ананд,
- Терра экспресс компанийн Ерөнхий захирал Ш.Алтанбагана,
- Хаан банк сангийн менежер М.Мандахмягмар,
- MDS Khanlex фирмийн партнер С.Батбуян нар оролцож байна.

Ингээд Байгаль даргыг хэлэлцүүлгээ эхлүүлэхийг урьж байна. Бид бүхэн төлөвлөгөөт цагаасаа 10 орчим минут хоцорч яваа гэдгийг танд хэлье.



“БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ” ХӨТӨЛБӨРИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ ЦАХИМ НЭЭЛТ

ПАНЕЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ: ОНОЛООС ПРАКТИКТ



О.БАЙГАЛЬ

ОУ-ын Эмэгтэйчүүдийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгч ба МУХАУТ-ын Дэд ерөнхийлөгч



ХИРОШИ ИШИДА

Саух Round Table бизнесийн манлайлагчдын олон улсын сүлжээ байгууллагын Япон дахь салбарын Гүйцэтгэх захирал



М.МАНДАХМЯГМАР

Хаан Банкны Сангийн Менежер



С.БАТБУЯН

Эм Ди Эс Хаанлекс ХХК-ийн Партнер



Ш.АЛТАНБАГАНА

Терра Экспресс ХХК-ийн Захирал



Х.АНАНД

Монос Групп ХХК-ийн Захирал

Арга хэмжээг дэмжигч байгууллагууд:



Панел хэлэлцүүлэг:

БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ: ОНОЛООС ПРАКТИКТ

ЧИГЛҮҮЛЭГЧ



О.БАЙГАЛЬ

Олон Улсын
Эмэгтэйчүүдийн
Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхимын
Ерөнхийлөгч ба
МҮХАУТ-ын Дэд
ерөнхийлөгч



Өнөөдрийн бизнес ба хүний эрх хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцож байгаа бүх оролцогч талууд, төр болон хувийн хэвшил, мөн энэхүү хөтөлбөрийг сонирхон үзэж байгаа бүх хүмүүстээ энэ өдрийн мэнд хүргэе. Миний нэр Байгаль. Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэд ерөнхийлөгч буюу олон улсын эмэгтэйчүүдийн худалдаа аж үйлдвэрийн танхимыг төлөөлөн оролцож байна. Мөн бизнес ба хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн гишүүн бөгөөд гүйцэтгэх хорооны гишүүнээр ажиллаж байгаа учраас өнөөдөр та бүхэнтэйгээ уулзаж байна. Энэхүү том хөтөлбөрийг эхлүүлэх, энэ багт хамтран ажиллах боломжийг олгосон байгууллагууддаа, хамтарч оролцож байгаа бүхий л талууд Европын Холбоо, НҮБХХ, ГХЯ болон бусад байгууллагууддаа талархал илэрхийлье.

Өнөөдөр бидний ярилцах зүйл бол Бизнес ба хүний эрх онолоос практикт сэдэв. Түрүүнд О.Амартүвшин ерөнхийлөгчийн нэлээд тодруулж хэлж байсан зүйлүүд бол шинэ тутамд гарч ирж байгаа энэ ойлголтуудыг бид нар хэрхэн олон нийтэд таниулах вэ? сурталчлах вэ? Ялангуяа танхимын болоод бусад бизнесийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын гишүүн байгууллагуудын үйл ажиллагаагаар дамжуулж хэрхэн нэвтрүүлэх вэ? гэсэн асуудлууд дээр олон ажил хийгдээд зарим хувийн хэвшлийн байгууллагууд, мөн Монголд ажиллаж байгаа олон улсын байгууллагууд үүн дээр нилээн хүчин чармайлт гаргаж ахисан түвшинд зарим байгууллагууд маань ажиллаж байна. Өнөөдөр бас өөрсдийн туршлага, сорилт мэдээлэл, бэрхшээлүүдээсээ хуваалцах гэж оролцож байгаа панелистууддаа талархал илэрхийлье.

Чиглүүлэгч О.Байгаль: Хүний эрхийг хүндлэх үүрэг нь өөрөө аль ч газар нутагт бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн аж ахуйн нэгж байгууллагуудад тавигдах дэлхий нийтэд мөрдөгдөж байгаа нийтлэг зан үйлийн стандарт гэж хэлж болох соёл бий болж байна. Өнөөдөр бидний урилгыг хүлээн авч “Саух round table” бизнесийн манлайлагчдын олон улсын сүлжээний Япон дахь салбарын гүйцэтгэх захирал Хироши Ишида оролцож байна.

- Өнөөдрийн панел хэлэлцүүлгийн эхний асуултыг Ишида сангаас асууя гэж бодож байна. Саух round table байгууллагын талаар та бидэнд товч мэдээлэл өгч, Азийн компаниудад хүний эрхийн зарчмуудыг нэвтрүүлэх туршлага болон сорилтуудын талаар Япон улсын жишээн дээр бидэнтэй үзэл бодол, туршлагаасаа хуваалцаач гэж урьж байна.



ХИРОШИ ИШИДА

Саух Round Table бизнесийн манлайлагчдын олон улсын Япон дахь салбарын сүлжээ байгууллагын Гүйцэтгэх захирал

Энэхүү чухал арга хэмжээний нээлтэд буюу Монголд НҮБ-ын удирдамж, зарчмуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээнд намайг урьсанд баярлалаа. Намайг Хироши гэдэг. Би Co-Round Table байгууллагын гүйцэтгэх захирал. Манай байгууллага бол 1986 онд Швейцар улсад байгуулагдсан ашгийн бус байгууллага юм. Гэхдээ бидний яг одоогийн гол зорилго бол Япон улсад НҮБ-ын удирдамж, зарчмуудыг компаниудын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх явдал болоод байна.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд бидний хувьд оролцогч талууд, ТББ, иргэний нийгмийн байгууллагуудын оролцогчдыг үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах юм. Эдгээр бүгд ялгаатай оролцогч талуудыг нэгтгэхийн тулд манай Саух round table байгууллагаас 2012 онд оролцогч талуудын үйл ажиллагааны оролцооны хөтөлбөрийг зохион байгуулсан. Тиймээс одоо бидэнд маш олон компаниуд, ТББ-ыг нэгтгэн дуу хоолойгоо өргөж байна.

Бид жил бүр 5-6 дугаар сарыг яриа хэлэлцээрийн улирал хэмээн зарлаж үйл ажиллагаа явуулдаг. Гэхдээ энэ нь дуу

хоолойгоо өргөх ажил бөгөөд энэхүү том хүрээний ажлын дор бид компани нэг бүрийг НҮБ-ын удирдамж зарчмуудад хэрхэн нэгтгэх тухай ажил багтана. Тиймээс бид компанийн удирдлагууд, гүйцэтгэх захирлуудаас эхлээд нийлүүлэгчийн сүлжээ, нөхөн сэргээлтийн төлөвлөлтөд хүргэж, энэ бүх мэдээллийг олон нийтэд хэрхэн хүргэх тухай бүхэл бүтэн цэс хөтөлбөрийг гаргаад байна. Тиймээс бид бүхэн хүний эрхийн бодлогууд, бизнесийн зохих шаардлагуудыг дагаж мөрдөх шаардлагатай байдаг учраас бидэнд компани нэг бүрт тохирсон энэ хүрээний цэс бий. Бид одоогоор Японд 68 корпорац дээр эдгээрийг хийж гүйцэтгээд байгаа бөгөөд тус зарчмуудыг хэрэгжүүлэхээр хүлээгдэж байгаа маш олон компаниуд байсаар л байна. Яг өнөөгийн энэ цаг мөчид Японы хувьд хүний эрхтэй холбоотой хамгийн үндсэн зорилт бол гадаадын ажилтнууд байна. Та бүхэн мэдэж байгаа байх. Манай Япон улсад корпорациуд маш хурдацтайгаар буурч байна.

Тиймээс эдийн засгийн үйл ажиллагааг хэвийн байлгахын тулд бидэнд гадаадын ажилчдын тусламж хэрэгтэй байгаа ч бид тэдэнд хүндэтгэлгүй хандаж байгаагаа ухаараад байна. Тиймээс энэ тогтолцооноос зайлсхийхийн тулд, төлөвлөлтийг гадаадын ажилчдад шударга байлгахын тулд бид олон япон компаниудыг тэдгээр гадаадын ажилчидтай холбох ажлыг хийхээр оролдож байгаа ч тэдний ихэнх нь тэдний 6, эсвэл 7-р үеийн нийлүүлэгчээр ажиллаж байна. Тиймээс яг одоогийн гол зорилго нь компаниудыг өөрсдийнхөө үнийн сүлжээ, нийлүүлэгчдээ хэрхэн тодорхойлоход нь тусалж байна. Энэ бол маш том зорилго, их ажил. Маш том компаниудын нэг агаарын тээврийн компани болох ANA -г танилцуулмаар байна. Тус компанид 20 гаруй мянган нийлүүлэгчийн маш олон нийлүүлэгчид байдаг. Тэгвэл нэг компани яаж энэ олон хорь, гучин мянган нийлүүлэгчийн олон мянган нийлүүлэгчид хүрнэ гэдэг нь маш том бэрхшээл юм. Тэгвэл бид бүхэн энэ бүх цэгүүдийг хооронд шинжлэх ухааны технологиор холбох систем бүтээсэн юм. Цэгүүдийг холбох нь гол ажил. Тиймээс бид тэдгээр гаднын ажилчдад хүрэх дуу хоолойг илрүүлэх тийм системийг бүтээгээд байна. Тиймээс бид гар утасны аппликейшн бүтээсэн нь бүх ажилчин энэ аппликейшнийг ашиглан үг хэлээ дамжуулах бөгөөд өөрсдийнхөө нийлүүлэгчидтэй холбоотой хүний эрхийн асуудлууд юу байгааг илрүүлэх юм. Бидний хийсээр ирсэн палм тосны үйлдвэр, коу-химийн үйлдвэрүүдтэй холбоотой адилхан асуудал гарч байгаа нь машинуудын ашиглаж байгаа бүх палм тос нь Японых биш байна. Бүх бүтээгдэхүүн, материал нь Индонез, Малайзаас ирж байна. Тиймээс бид энэ тосны асуудлаар Индонезийн 5000 гаруй жижиг фермерүүдтэй холбогдох ажлыг хийсээр ирлээ. Гэхдээ өнөөдөр онлайн системийг ашиглаад ярилцаж, компаниудтай, тэдгээр фермерүүдтэй шууд мэдээлэл солилцох боломжтой болж маш сонирхолтой асуудлыг олж илрүүлээд байна. Энэ нь компаниудыг эрсдэлээс сэргийлэх боломжтой. НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдамж, зарчмуудын тухайд; НҮБ-ын удирдамж зарчмуудын чухал хэсэг нь гарч болох эрсдэлийг хэрхэн илрүүлж түүнийг бууруулах нь маш чухал гэдэг.

“

Тэгвэл тухайн компани хүний эрх нь зөрчигдөж байгаа тэдгээр ажилчидтай хэрхэн шууд харилцаж, тэдэнд хүрэх вэ гэдэг нь хамгийн чухал юм. Тэдгээр ажилчдаас суралцах нь бидний практик ажил болоод байна.

”

”

Та бүхэнд баярлалаа.

Чиглүүлэгч О.Байгаль: Маш их баярлалаа Ишида сан. Та бүхний туршлагаас суралцаж, хамтын ажиллагааны өргөн боломжууд нээгдэнэ гэж найдаж байна.

Чиглүүлэгч О.Байгаль: Дараагийн панелист Хаан банк сангийн менежер М.Мандахмягмарыг урьж байна. Бизнесийн байгууллагууд тэр дундаа банк санхүүгийн салбарт тогтвортой хөгжлийн чиглэлээр олон санал санаачилгууд гаргаж ажил хэрэг болгодог. Тэр дундаа салбартаа тэргүүлэгч Хаан банкны хувьд өөрийн үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн асуудлуудыг бодлогын түвшинд анхаарч, бусад байгууллагуудаа түүчээлэн ажилладаг жишээнүүдийг бид ярьж болно. Энэ хүрээнд Хаан банкны сайн туршлагаас хуваалцаасай гэсэн үүднээс энэхүү хэлэлцүүлэгт Хөгжлийн бодлого нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч сангийн менежер М.Мандахмягмар оролцож байгаа юм.

- Хаан банк бол Даян дэлхийн гэрээнд нэгдсэн Монголын цөөхөн байгууллагуудын нэг төлөөлөл. Та бүхэн тус гэрээний хүрээнд тогтмол тайлангаа хүргэгч, идэвхтэй гишүүнээр оролцож байдаг. Даян дэлхийн гэрээнд нэгдсэнээр танай байгууллагад ямар давуу талууд бий болж байна вэ? Даян дэлхийн гэрээнд хүний эрхийн зарчмыг хэрхэн хэрэгжүүлж бизнесийн үйл ажиллагаатайгаа уялдуулж ажиллаж байна вэ? Энэ зарчмыг ажил хэрэг болгоход тулгарч байгаа бэрхшээлүүдийн талаар өөрсдийн туршлагаас хуваалцаач?



М.МАНДАХМЯГМАР

Хаан Банкны Сангийн
Менежер



ХААН БАНК

Энэхүү панелд урьж оролцуулж байгаа та бүхэнд баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

НҮБ-ын дэргэдэх Даян дэлхийн гэрээ сайн дурын санаачилга нэгдэл байгаа. Тус гэрээнд 2018 онд Хаан банк дахин нэгдэж орсон. Ер нь НҮБ-ын Даян дэлхийн гэрээ 4 үндэслэл, 10 зарчимтай байдаг. Үүнээс эхний 2 зарчим нь яг хүний эрхтэй холбоотой зарчим байдаг. Энэ дагуу 10 зарчмыг яаж хэрэгжүүлдэг вэ гэдэг үйл ажиллагааны тайланг жил болгон өгдөг.

Давуу талуудын хувьд ерөнхийдөө олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн зарчим стандартыг дагаж мөрдөх гэдэг нь зөвшөөрөгдсөн стандартаар үйл ажиллагаа явуулах боломжоор хангадаг. Дээрээс нь үүнтэй холбоотой бодлогын бичиг баримтууд, гарын авлага материалуудыг өөрсдийн бүх үйл ажиллагааны бодлого чиглэлд тусгах, хэрэгжилтийг хангах давуу талуудтай.

Энд дэлхийн маш олон том байгууллагууд гишүүнчлэлтэй бүртгэлтэй байдаг. Тэдгээр маш олон том бизнесүүдээс суралцах, туршлага судлах, харилцаа холбоо тогтоох боломжууд нээлттэй байдаг. Дээрээс нь тухайн компаниудад гарч байгаа сайн туршлагаас суралцах, өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжууд бий. Ер нь бол нийтлэгээр хүний эрх гэхээр хүний эрх зүйн гэж ойлгогдоод ажилтнуудынхаа эрх ашгийг хамгаална гэдэг. Гэтэл аливаа бизнесүүдийн үйл ажиллагааны бүх түвшинд хүний эрхийн асуудал хамаарч байх ёстой. Яаж бизнесийн үйл ажиллагаатай уялдуулж байна вэ гэхээр Монгол улсын өнцөг булан бүрт ажиллаж байгаа Хаан банкны 6400 гаруй ажилтнууд байдаг. Хүн ажиллаж байгаа учраас хүний эрх, хөдөлмөрлөх эрхийн асуудал мэдээж яригдана. Ялангуяа энэ цар тахлын үед ажилтнуудын эрүүл мэнд, амь нас нэн тэргүүнд тавигдах асуудал. Ажилтнуудаа даатгалд хамруулах, цалин хөлсийг бүрэн олгох, халдвар хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй байдлыг чанд баримтлан ажиллах, мөн Монгол улсад мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хуульд харшлахгүйгээр үйл ажиллагаа явуулна. Үүнээс гадна зөвхөн байгууллагын хүний нөөцөөр хязгаарлахгүй.

Харилцагчийн үйлчилгээний стандарт бол хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй, нас, шашин шүтлэг, гарал үүсэл, албан тушаалаар нь ялгаварлахгүй үйлчилгээ үзүүлнэ. Банк гэдэг зээл, хадгаламж, төлбөр, тооцооны асуудлаар харилцагчидтай холбогддог эдгээр үйлчилгээний хүрээнд хүний эрхийн асуудлуудыг авч хэлэлцдэг. Жишээ нь зээл олгох гэж байгаа харилцагчдад байгаль орчны эрсдэлийн үнэлгээг хийдэг. Энэ үнэлгээг хийж байна гэдэг бол асуулгад танай байгууллага хүний эрхийн бодлого журмаа яаж хэрэгжүүлдэг вэ? Хүүхдийн хөдөлмөр байна уу? түүнийг үл тэвчих асуудал дээр танай байгууллага ямар бодлого, бичиг баримтаар хэрэгжилтээ хангаж байгаа вэ? гэдэг ч юм уу эргээд эрсдэлийг нь үнэлж, хэрхэн сайжруулж болох тухай зөвлөмж зөвлөгөө өгдөг. Цаашлаад хамтарч тухайн асуудалд хяналт хийж явах жишээгээр санхүүгийн хөшүүрэг дээр нь хамтран ажилладаг гэсэн үг. Дээрээс нь сүүлийн жилүүдэд бэлтгэн нийлүүлэлтийн гинж, сүлжээ гэж ярьж байна. Энэ бол маш сайн системтэй хөгжиж байна. Банк өөрийн бэлтгэн нийлүүлэлтийн удирдлагын тогтолцоогоо шинэчилсэн.

Манай банктай хамтарч ажиллах гэж байгаа бэлтгэн нийлүүлэгчиддээ бид тэдгээр шаардлагуудыг тавьж эхэлсэн. Танай байгууллага бэлтгэн нийлүүлэлтийн чиглэлээр хамтран ажиллах гэж байгаа бол танай хүний нөөцийн бодлого хүний эрхийг яаж хамгаалдаг юм? Яаж эрхэмлэдэг юм? Танай бараа бүтээгдэхүүн үйлчилгээнд чинь хүүхдийн хөдөлмөр байдаг уу? Оролцдог уу? гэж асуух жишээтэй.

Мөн та нарын оруулж ирж байгаа бүтээгдэхүүн чинь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө бий юу? гэх мэт бусад төрлийн асуултуудыг авч эхэлж байна. Нөгөө талаасаа оролцогч талуудыг хүний эрхийг хамгаалах асуудал дээр татан оролцуулах, тэдний үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэдэг мэдлэг олгох нөлөөллийн ажлууд давхар явагддаг. Бэрхшээлийн хувьд дотоод үйл ажиллагаан дээр харьцангуй гайгүй байдаг. Сая миний хэлсэн бэлтгэн нийлүүлэлтийн гинж сүлжээнд зарим тохиолдолд бэрхшээлүүд байдаг. Яагаад гэвэл бид энэ асуулгуудыг тавиад эхлэхээр ялангуяа жижиг дунд бизнес, бичил бизнесүүдийн хувьд энэ талын мэдлэг ойлголт байхгүй, бичиг баримт байдаггүйн улмаас тавьж байгаа шаардлагуудыг маань давж гарч чадахаа болих гээд байдаг. Энэ үед Монгол Улсын нөхцөлд амьдралд ойр асуултуудыг бид нар тавьж чадаж байна уу? гэдэг асуудал эргээд бидэнд тулгардаг. Яг олон улсын стандартын дагуу шаардлага тавиад явбал бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх компани олдохгүй болох нөхцөл байдал үүсэхээр байдаг. Тиймээс Бизнес ба хүний эрх гэдэг үндэсний хөтөлбөрийг боловсруулж байгаа нь бизнесийн байгууллагуудад маш их дэмжлэг, нэгдсэн ойлголттой болоход тусална гэж ойлгож талархан хүлээн авч байна. Баярлалаа.

Чиглүүлэгч О.Байгаль: М.Мандахмягмарт баярлалаа. Бизнес ба хүний эрх хөтөлбөр олон улсад хэрэгжиж байгаа бизнес хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад бол гол том тоглогч компаниудын үүрэг оролцоо тэдгээрийн ханган нийлүүлэлтийн сүлжээ, харилцагч үйлчлүүлэгч нартаа хандсан үйл ажиллагаагаараа дамжуулан таниулан сурталчлах бол маш чухал ажил гэдгийг олон улсад ярьж байгаа. Хаан банк бол энэ асуудал дээр манлайлан ажиллаж, үйлчлүүлэгч харилцагчид бүх сүлжээндээ энэхүү ойлголтыг бодлогыг баримт бичгийн хүрээнд нэвтрүүлж байгаад талархалтай байна.

Бизнес хүний эрхийн зарчмуудыг бид нар яриад эхлэхээр бизнесийн үндсэн үйл ажиллагаанд тогтмол зохицуулагдаж байгаа хууль тогтоомжийн талаар яригдана. Түрүүнд хөдөлмөрийн тухай хуулийн талаар О.Амартүвшин ерөнхийлөгч, С.Мойлтмаа зөвлөх нар ярилаа. MDS Khanlex хуулийн фирмийн партнер С.Батбуянгаас дараах асуудлыг тодруулъя. MDS Khanlex хуулийн фирм нь Бизнес ба хүний эрх, бизнес ба хүүхдийн эрхийн чиглэлээр өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлж үүрэг амлалтаа өгөөд явж байгаа байгууллага.

Та бүхэн одоо хийж байгаа үйл ажиллагаагаа товч танилцуулж Монгол улсын хууль тогтоомжтой холбоотой ямар уялдаа холбоо байна вэ? Тэр дундаа хууль тогтоомж дотор иргэний хуулиуд их дурьдагдаж байгаа. Бизнес ба хүний эрхийн баримтлах зарчмуудтай холбоотой иргэний хууль хэрхэн хамаарч байгаа талаар туршлага, мэдээллээ хуваалцаач гэж хүсч байна.



С.БАТБУЯН

**Эм Ди Эс Хаанлекс
ХХН-ийн Партнер**



Сайн байцгаана уу? Өнөөдрийн арга хэмжээнд оролцож байгаадаа их баяртай байна. Эхний хэсэгт манай байгууллага хуулийн фирм ямар үйл ажиллагаа явуулж байгаа талаар, хүүхдийн эрх болон хүүхэд хамгаалалтай холбоотой ямар үйл ажиллагаа явуулж байгаа талаар товчхон мэдээлэл өгье.

Бид хүүхдийн эрхийг дээдлэгч хамт олон байж, хүүхдийн эрхийг хүндэтгэсэн хамгаалсан нийгэм бий болгох, төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулна гэсэн зорилго тавьсан. Энэ хүрээнд эхний ажлууд хийгдээд явж байна. Үүнд хүүхдийн эрхийг хамгаалах баримт бичиг гаргасан. Мөн хүүхдийн эрхийг хамгаалах, хангах чиглэлээр зарим үйл ажиллагаа хөтөлбөр хэрэгжүүлж ажиллаж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах бодлогын баримт бичиг яагаад гаргасан бэ? Үүгээр юуг зохицуулж байна вэ? гэвэл энд дийлэнхдээ дотооддоо болон хөдөлмөрийн харилцаанд мөн гадагшаа болон үйлчлүүлэгчидтэй харилцах нийгэм рүү харилцах хүрээнд ямар бодлого баримтлах вэ? гэдэг үндсэн баримт бичиг болгож гаргасан.



Тухайлбал бага насны хүүхэдтэй ажилтнуудад сар бүр хүүхдийн өдөр гэж нэг өдрийн чөлөө олгох мөн ажлын цагийн уян хатан зохицуулалтуудыг хийж байна. Мөн хүүхдийн дуу, дүрс хүүхдийн эрхтэй холбоотой нууц, хувийн амьдралтай холбоотой нууцыг хангах зохицуулалтуудыг заасан.



Хүүхэд ажлын байран дээр ирэх, зочлох үед ямар арга хэмжээ авах, аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар зохицуулалт хийсэн. Хүүхдээр хууль бус хөдөлмөр эрхлүүлдэг байгууллага байх юм бол хамтран ажиллахаас татгалзах амлалт гаргасан. Хүүхдийн эрхийн зөрчил гаргасан бол үүнийг холбогдох байгууллагууд нь хэрхэн мэдээлэх талаар журам гаргасан ба журмын хэрэгжилтийг хангах хүрээнд хөдөлмөрийн хариуцлага тооцох зохицуулалт хийсэн. Үйлчлүүлэгчиддээ хүүхэд хамгааллын тухай мэдээ, мэдээллийг хэрхэн хүргэж байх талаар энэ бодлогын бичиг баримтад тусгасан. Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр нийтэд чиглэсэн үйл ажиллагаанууд явуулж байгаа. Тухайлбал хүүхдийн эрхийг хамгаалах стандартуудыг үнэ төлбөргүй боловсруулж нийтэд түгээх, эрх бүхий байгууллагуудад санал болгох төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Эхний ээлжинд хүүхэдтэй холбогдох хүүхдийн эрхийн контентын төсөл боловсруулаад явж байгаа. Мөн компани аж ахуйн нэгжүүд хүүхдийн эрхийг дотооддоо мөрдөх хүүхдийн эрхийн баримт бичиг, стандартыг боловсруулж санал болгох ажлыг хийж байна. Мөн цаашид хүүхэд хамгаалах эрх зүйн чиглэлийн сургалтын хөтөлбөрийг үнэ төлбөргүй боловсруулах ажлыг төлөвлөж байна. Явуулж буй үйл ажиллагаатай холбогдуулан тодорхой хэмжээнд нөлөөллийн үйл ажиллагааг явуулах шаардлагатай гэж харсан. Goflu чөлөөнд нэгдээд уриалга гаргасан. Цахим хуудас дээр хүүхдийн эрх гэдэг цэс нээсэн байгаа. Энэ хуудас болон социал хуудсаар дамжуулж хүүхдийн эрхтэй холбоотой контентууд бэлтгэж түгээх ажил тогтмол хийгдэж байна. Ерөнхийдөө хүүхдийн эрхийг хангах чиглэлд ийм ажлуудыг хийж байна.

Монгол Улсад хүний эрх болон бизнесийн зарчмуудтай холбоотой хууль тогтоомжийн орчны талаар ерөнхийд нь авч үзэхэд мэдээж олон улсын хэм хэмжээтэй баримт бичгүүд бол бий. Түүнээс гадна дотоодын үндэсний эрх зүйн зохицуулалтуудыг авч үзэхэд Монгол улсын Үндсэн хуулиас эхэлж болно. Үндсэн хуулиар төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах нийгэм эдийн засгийн баталгааг бүрдүүлэх, хүний эрхийг зөрчих, тэмцэх, хөндөх зэргийг сэргээн эдлүүлэх үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллана гээд заачихсан. Энэ бол энэ үйл ажиллагааны суурь болох болов уу? гэж бодож байгаа. Монгол Улс бол хүний эрхийг хамгаалахад чиглэсэн олон улсын 30 гаруй гэрээ, конвенцэд нэгдэж орсон байна. Эдгээр нь хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэлд явж байгаа. Энэ арга хэмжээний эхэнд дурдагдаж байсан “Алсын хараа 2050” гэж Монгол улсын урт хугацааны

бодлого байгаа. Үүнд үе шаттайгаар хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бүрдүүлнэ гэж зохицуулсан байгаа юм билээ. Хууль тогтоомжийн хувьд бол дурьдагдаж байгаа хөдөлмөрийн хууль тогтоомж байж болно. Жендерийн эрх тэгш байдал, хүүхдийн эрх хангах тухай, хүний эрхийн байгууллага, хүний эрхийн хамгаалагчидтай холбоотой хууль тогтоомж, компани, төрийн худалдан авалттай холбоотой хууль гээд салбар салбарын хууль тогтоомжийг дурьдаж болно. Одоогийн байдлаар манай хууль тогтоомж дээр баримтлах зарчмуудтай холбоотой шууд зохицуулалт зарим тохиолдолд байхгүй. Хуулийн хувьд бол ерөнхийдөө хүний эрхэнд сууриглагдах байдлаар боловсруулагдаж гардаг гэж үзэх юм бол төсөөтэй байдлаар, суурь болгоод хэрэглэх боломжийн зохицуулалт тодорхой хэмжээнд бий. Компани, хуулийн этгээдтэй холбоотой хууль тогтоомж дээр хөрөнгө оруулалт болон санхүүжилттэй холбоотой хуулийг ерөнхийд нь авч үзэхэд нарийвчлан заасан нөхцөл байхгүй боловч Монгол Улсад банк санхүүгийн байгууллагууд энэ салбарт тогтвортой санхүүжилт, ногоон санхүүжилтийн санаачилгууд гарган хэрэгжүүлээд явдаг. Мөн мөнгөний бодлого, тогтвортой санхүүгийн бодлогын үйл ажиллагааг дэмжих хүрээнд тодорхой зорилтууд тусгасан байдаг. Мөн санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр баталсан. Үүнтэй холбоотой банкнуудаас ногоон зээлийн статистик мэдээллүүдийг авч зарлаж явдаг юм билээ. Хөрөнгө оруулалтын сангийн хүрээнд яг хуулиараа хүний эрх бизнесийн зарчмуудыг мөрдөнө гэж заасан нөхцөл байхгүй ч гэсэн хөрөнгө оруулалтын сангийн хувьд хөрөнгө оруулалтын бодлого гэж гаргадаг. Тэр бодлогоор хүний эрхийг хангах нөхцөл, зохицуулалтуудыг тусгаад явах одоогийн хууль тогтоомжийн боломжууд бий. Мөн байгаль орчны хууль тогтоомж, хувийн мэдээлэл нууцлалтай холбоотой хууль тогтоомж байдаг. Нууцлалын тухай хуулиуд бол 1995 оны хуулиудаар зохицуулагдаж байдаг. Хувь хүний хөгжил, хамгаалах асуудал зохицуулалтгүй байсан бол одоо шинээр хувь хүний мэдээллийг хамгаалах хууль боловсруулагдаад явж байна. Бизнес хүний эрхийг хамгаалахад иргэний хуулийг хэрэглэж болохоор харагдаж байна. Хууль тогтоомжийн ерөнхий зохицуулалтууд байгаа. Хууль тогтоомжоор зохицуулснаар энэ асуудал хязгаарлагдахгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Ариунбилэг: С.Батбуяндаа баярлалаа Khanlex хуулийн фирм нь бизнес ба хүний эрхийн зарчмуудыг бизнесийнхээ үйл ажиллагаандаа нэвтрүүлэх явцдаа хуулийн зөвлөгөө үйлчилгээ өгөөд ажиллаж байгаа Монголд анхны эхлэл тавьж байгаа байгууллага гэж ойлгосон. Та бүхэн хамтын ажиллагааг өргөжүүлж Монголын олон компаниудад эдгээр зарчмуудыг нэвтрүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Эрүүл аюулгүй орчны тухай, байгаль орчны асуудлууд, түүнтэй холбоотой хөрөнгө оруулалтын асуудлуудыг ярьж байна.

Ариунбилэг: Хаан банкттай адилхан Даян дэлхийн гэрээнд Монгол Улсаас нэгдэн орж тайлангаа илгээдэг цөөхөн компанийн нэг бол “Терра экспресс”. Өнөөдрийн үйл ажиллагаанд компанийн захирал Ш.Алтанбагана оролцож байна. “Терра экспресс” компани нь ложистик уул уурхайн чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Ялангуяа эрүүл, аюулгүй орчинд ажиллах эрх, тэдгээрийг хэрэгжүүлэх тухайд өөрийн компанийн үйл ажиллагаанд таван шатлал бүхий аргачлалыг нэвтрүүлсэн, ISO14001 стандартыг нэвтрүүлэгч, тэргүүлэгч жишиг бүхий компаниудын нэг юм.

- Даян дэлхийн гэрээнд нэгдэж ороод дараах алхмуудыг хийхэд хүний эрх болоод бизнестэй, зарчимтай холбоотой өөрийн туршлага мэдлэгээс бид бүхэнтэй хуваалцаж, сорилтуудынхаа талаар яриач хэмээн урьж байна.



Ш.АЛТАНБАГАНА

Терра Экспресс ХХК-ийн
Захирал



Өдрийн мэнд.

“Терра экспресс” компанийг товч танилцуулахад байгуулагдаад 11 жил болж байна. Уул уурхай майнинг ложистик чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Уул уурхайн компаниудын тээвэрлэлтийн шийдлийг гаргаж ажилладаг.

Түрүүнд дурьдагдсан хүнд нөхцөл байдалд байгаа нүүрсний тээврээс эхлээд, Монголдоо тэргүүлж байгаа Оюу толгой компанийн ложистик сервис шийдэл дээр ажиллаж байгаа компани юм.

2018 онд Монгол Улсаас Хаан банкттай хамт Даян дэлхийн гэрээнд нэгдсэн. Даян дэлхийн гэрээний хувьд дараагийн түвшинд гараад явж байгаа ба илүү үр дүнтэй хэлбэрт орсон гэж бодож байна. Тиймээс компанийн бодлого чиглэлд нийцэж байгаа учраас нэгдэн ороод, тайлангаа 3 дахь жилдээ өгсөн. Гурван жилийн хугацаанд манайх бодлогын түвшинд анхан шатны нэгж хүртэлх 5 түвшинд үндсэндээ энэ зарчмуудыг тэр дундаа хүний эрхийн зарчмуудыг интегритэт хийх зарчмууд дуусч байна гэж үзэж болно.



Энэ 5 үе шатыг маш товчхоноор жишээтэй хэлэх юм бол бид байгууллагын 4 үнэт зүйлсийн хоёрт нь буюу нэгдүгээрт оролцогч талуудын тэгш байдал буюу оролцоог хангах үнэ цэнэ, эрүүл аюулгүй орчинд ажиллах гэсэн энэ 2 үнэт зүйлсийг байгууллагын үнэт зүйлс болгож тусгасан. Үнэт зүйл болгож тусгаад зогсохгүй бүх оролцогч талууд ялангуяа хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын гэрээгээрээ баталгаажуулж компанийн засаглалын түвшинд гүйцэтгэх удирдлага болон бусад бүх хамтран ажиллагчид, ханган нийлүүлэлтээс эхлээд манай гол оролцогч, ялангуяа ажиллагсад энэ үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч дэмжсэн тохиолдолд нэгддэг.

Жишээлбэл ажлын ярилцлагаас эхлээд томоохон гэрээндээ баримталж байгаа гэж хэлж болно. Хоёрдугаарт бодитой болон байгууллагын стратеги бодлогын түвшинд зорилт тогтоож KPI хийхгүй бол энэ үйл ажиллагаанууд хэрэгжих боломжгүй. Тиймээс бид 3 жилийн стратеги төлөвлөлтөд хүний эрхтэй холбоотой тодорхой зорилтуудыг тусгасан байдаг. Ялангуяа байгууллагын хөгжлийн зорилт дотор хүний эрх гэсэн дэд зорилт байгаа. Энэ зорилтууд гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-өөр хэлэлцэгдсэн стратеги төлөвлөгөөнд батлагдаад хүмүүсийн KPI болон урамшуулал бусад зүйлүүдтэй холбоотой хэрэгждэг.

Сонирхуулж хэлэхэд ажиллагсдын оролцоо, эрх ашгийг хангах, хөдөлмөрийн мөлжлөгөөс хамгаалах чиглэлд гэхэд жилийн төсөвт тодорхой хувийг эрүүл, аюулгүй байдлын ажиллах орчныг бүрдүүлэхэд заавал зарцуулна гэсэн лимит тогтоосон байдаг. Хамгийн бага цалингийн хэмжээ 1 сая төгрөг байна. Үүнээс доош байх цалингийн бодлого байхгүй.



Маш сонирхолтой нэг бодлого бол ажиллагсдын цалингийн сан нийт зардлын 50-иас доошгүй хувийг эзлэх ёстой гэдэг ийм тодорхой, бодитой зорилтуудыг хөрөнгө оруулагч болон гүйцэтгэх удирдлагын түвшинд тодорхойлсон байдаг.



Гуравдугаарт бизнесийн процессийн үе шат. Энэ үе шатанд манай хамгийн гол үйл ажиллагаа хэрэгждэг. Даян дэлхийн гэрээтэй холбоотой 10 гаруй дотоодын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд 5-б хөтөлбөр хүний эрхтэй шууд холбогддог. Тухайлбал ялгаварлан гадуурхлын эсрэг өөрийн хөтөлбөртэй. Ажлын байрны тэгш байдлыг хангах, жендерийн тэгш байдлаас эхлээд аливаа нэг байдлаар хүмүүсийн тэгш оролцоог хангах хөтөлбөртэй. Мөн орон нутгийн оролцоог хангах зэргээр бодитой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Дөрөвдүгээрт байгууллагын бүтцийн түвшинд ажиллагсдын ажлын байрны тодорхойлолт, түрүүнд дурьдсан менежмент ба обжектив гэдэг зорилтоо тодорхойлж явдаг энэ хүрээнд хүний эрхийн бодлого, чиглэл үүргүүд нь бодитоор тусгагдаад ажлын байрны тодорхойлолтод ордог. Хамгийн сүүлд өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж дээрх, үйл ажиллагаанууд нь хэрхэн бодитоор хэрэгжиж байгаа талаар үнэлгээ хийн сайжруулах чиглэлээр ажилладаг. Мөн энэ шатанд тодорхой хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

Чиглүүлэгч О.Байгаль: Ш.Алтанбагана захиралд маш их баярлалаа. Бусад компаниудынхаа түүчээ болж энэ чиглэлийн болоод бусад өөр үйлчилгээ, бүх төрлөөр ажилладаг бизнесийн байгууллагууд та бүхнээс мэдлэг туршлагаа судлаад, суралцаад та бүхний хамтын оролцоотойгоор дараа дараагийн ханган нийлүүлэлтийн сүлжээний байгууллагууд ийм олон стандартуудыг хэрэгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Чиглүүлэгч О.Байгаль: Дараагийн оролцогч бол Монос группын Гүйцэтгэх захирал Ананд. Монос группын хувьд 2019 оноос эхлээд НҮБ-ын Хүүхдийн сангийн техникийн туслалцаатайгаар хүүхдийн эрх ба бизнесийн зарчмуудад нэгдэн орж, тухайн зарчмуудаас үүрэг амлалтаа өгөөд явж байгаа Монголын тэргүүлэгч групп, компаниудын нэг юм. Мөн цар тахлын эсрэг арга хэмжээ авч, хүний эрхийн сөрөг нөлөөллүүдийг багасгах чиглэлд томоохон алхмуудыг хийж ажиллаж байгаа тэргүүлэгч компани юм.

- Монос группийн хувьд одоогийн хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, цаашид төлөвлөж байгаа ажлууд болон өнөөдрийн бизнес ба хүний эрхийн энэ хөтөлбөрт та бүхэн хэрхэн хүчин чармайлт гарган ажиллаж, ямар уриалгыг бусад бизнесийн байгууллагууддаа хүргэх вэ?



Х.АНАНД

Монос Групп ХХК-ийн
Захирал



Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Манай компани анх 1990 онд байгуулагдсан бөгөөд эм, гоо сайхны үйлдвэр, эмийн импорт худалдаа, эмийн сав, эрүүл мэндийн хүнсний үйлдвэр гэх мэт үйл ажиллагаа явуулдаг байлаа.

Бизнесээ өргөжүүлж эрдэм шинжилгээний хүрээлэн, эрүүл мэнд шинжлэх ухааны сургууль гэх мэтчилэн 15 охин компанитай үйл ажиллагаа явуулж байна. Одоогийн байдлаар нийт 2000 гаруй ажиллагчидтай. Анх бид 2008 онд компанийн засаглалыг сайжруулах, бизнесийн тогтвортой орчныг хөгжүүлэхийн тулд гаднын хөрөнгө оруулалт хайсан. Тэр маань амжилттай болоод 10 гаруй жил засаглалаа сайжруулсан. Одоо улам сайжруулан ажиллаж байна.

Харин 2 жилийн өмнөөс бид илүү хүн рүүгээ чиглэх зорилт тавиад ажиллаж байна. Манай байгууллагын хүний нөөцийн санаачилгаар НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилгоос 2 зорилгыг хэрэгжүүлж байна.

Эхнийх нь хүүхдэд ээлтэй бизнесийн чиглэлд үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал:



Бид оффис болгон дээр нийт 13 хүүхдийн өрөө байгуулсан. Ковид-19 цар тахалтай холбоотой цэцэрлэг сургуулиудыг хаасан. Үүнээс шалтгаалж ажилтнуудынхаа хүүхдүүдийг гэрт нь харах хүнгүй байвал, зайлшгүй ажлын байранд ирж ажиллах шаардлагатай нөхцөлд хүүхдийн өрөө гарган ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, тэр өрөөнд унтаж амрах, хичээл хийх зэрэг нөхцөл боломжоор хангаж бэлтгэсэн.



Энэ нь яваандаа улам өргөжөөд явах байх.

Дараагийнх нь ажилтнуудын эрүүл мэндийн асуудал юм. Энэ асуудлын хүрээнд бид ажилтнуудынхаа дархлааг дэмжиж витаминаар хангахаас гадна жил бүр шинжилгээ оношилгоо, эрүүл мэндийн даатгалд хамруулж байна. Мөн жил бүр спорт наадам зохион байгуулдаг бөгөөд тэдэнд зориулсан фитнесстэй болж байна. Энэ үүднээс хариуцлагатай бизнес болон тогтвортой хөгжлийг улам бүр хөгжүүлж байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тал дээр гэвэл 2000 гаруй ажиллагсдын 73 хувь нь эмэгтэйчүүд байдаг. Үүнтэй уялдуулан байгууллагын дотоод дүрэм журмыг боловсруулсан. Нийт захирлуудын 50%, ТУЗ-ийн гишүүдийн 50% нь эмэгтэйчүүд байдаг. Үүний дагуу бид HR ISO30400 стандартыг Монголд анх удаа нэвтрүүлсэн. Хүний нөөцийн энэ стандартыг нэвтрүүлсэн нь манай группын нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага юм. Нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагааны тогтолцоог улам боловсронгуй болгох зорилготой. Засаглалаа улам сайжруулах үүнийг дагаад гүйцэтгэл, бүтээмж, ажиллах орчноо бас сайжруулаад явж байна.

Мөн компани болгон дээр ажлын уян хатан цагийг өөрсдийн үйл ажиллагаанд зохицуулж гаргасан. Ковид 19-тэй холбоотой дижитал шилжилтэд маш хурдан шилжиж орлоо. Манай нийт ажилтнуудын 30-аад хувь нь гэрээсээ ажиллаж байна. Дээрээс нь цар тахлын үед гол фронт дээр ажиллаж байгаа ажилтнуудын сэтгэл зүйн дарамт, сэтгэл санааг дэмжихийн тулд бид судалгаа хийж компани бүр дээр долоо, долоо хоногоор сэтгэл зүйч ажиллуулж эхэлсэн. Сонирхсон хүмүүстэй тус тусад нь уулздаг. Нийт ажилтнуудын аюулгүй байдлыг хангах үүднээс ажлын байрны аюулгүй байдлын стандартыг 3 үйлдвэр дээр хэрэгжүүлж байна. Энэ стандарт, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бидний цаашдын тогтвортой хөгжил төдийгүй 3 үйлдвэрлэлээр гадагшаа дэлхийн зах зээлд гарах, экспорт хийх, худалдаа хийх тал дээр нилээн дөхөм болно гэж бодож байна. Монголын бусад компаниудыг уриалж, хүний нөөцийн ISO30400 стандартыг нийгмийн хариуцлагын хүрээнд чөлөөт ба стандарт хэмжил зүйн газар хөрөнгө оруулж үнэгүй өгсөн. НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилгыг бусад компаниуд тодорхой хэмжээнд хэрэгжүүлээсэй гэж хүсч байна. Та бүхэнд баярлалаа.



Чиглүүлэгч О.Байгаль: Манай оролцогч талуудын хэлснээр бизнес ба хүний эрхийн зарчмууд, өнөөдөр нээлтээ хийж байгаа энэхүү арга хэмжээг олон нийтэд хүргэх, бизнес тогтвортой хөгжих, цаашлаад эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгоход хамтын оролцоог хамгийн их чухалчилж байна. IDA байгууллагуудын хувьд гишүүн байгууллагуудаараа дамжуулаад бизнес ба хүүхдийн эрхийн зарчмуудыг НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлдэг. Мөн 2011 онд батлагдсан бизнес ба хүний эрхийн зарчмуудыг энэ жил гишүүн байгууллагуудаараа дамжуулаад хэрэгжүүлэхийг уриалж байна. Энэхүү уриалгад нэгдэн орж бидний санаачилгыг дэмжин оролцдог Монос группийн нийт хамт олонд талархаж байгаагаа илэрхийлье.

Чиглүүлэгч О.Байгаль: Нийт панелистуудынхаа дунд нэг асуулт асуугаад, та бүхний сэтгэгдлийг үлдээж өнөөдрийн панелаа дуусгая гэж бодож байна. Бизнес ба хүний эрх гэдэг бүс нутгийн долоон оронд хэрэгжих гэж байгаа энэхүү хөтөлбөр Монгол улсад 2023 он хүртэл хэрэгжүүлэхээр албан ёсоор нээлтээ хийж байна. Бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулж манлайлж байгаа байгууллагын хувьд та бүхний зүгээс бусад бизнес эрхлэгчиддээ өгөх уриалга зөвлөмж, санал, санаачилга байвал 1-2 минутад багтаагаад өөрсдийн саналаа хэлээч хэмээн урьж байна.



Хироши Ишида:

Маш их баярлалаа. Их чухал асуулт байна. Бусад компаниудыг

хэрхэн урамшуулах тухайд миний бодлоор тухайн компаниудад энэ олон хүнийг хэрхэн яаж удирдан явуулахыг ойлгуулах нь чухал. Ер нь бид муу мэдээний сөрөг нөлөөг сонсох дургүй, эргэлзэж хүлээн авдаг. Гэхдээ нэгэнтээ бэрхшээлийг давах гэж оролдохдоо бид НҮБ-ын удирдамж, зарчмуудтай арав гаруй жил ажиллаж байгаагийн хувьд энэ зарчмууд нь эсрэг-сөрөг тал биш, харин ч компаниудад сайн боломж авчирдаг учраас байгууллагууд, ТББ-тай хамтран ажиллаж эхлэхдээ хамтын ажиллагааг бүтээлчээр бий болгодог. Энэ нь оролцогч талуудын дунд итгэлцэл бий болгож, компани тус бүрд хамтрагчдыг бий болгосноор нөхөд буюу түншүүд болдог. Хэдийгээр заримдаа шүүмжтэй байдаг ч заримдаа ярилцаад, яриа өрнүүлж эхлээд, тэднийг хянуур сонсох шаардлагатай бөгөөд тэр нь сайн боломж, шинэ боломж нээгдэнэ.

Энэ бол бидний туршлага. Баярлалаа.



М.Мандахмягмар:

Банкны салбар тогтвортой хөгжлийн 17

зорилгод нийцүүлэх тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг маш их эрчимтэйгээр салбар нэгжүүд, арилжааны банкнууд, зохицуулагч харилцагч байгууллагуудаараа дамжуулан идэвхтэй оролцдог. Энэ бол зөвхөн салбар, ганц сегмент, нэг байгууллага хувь хүний асуудал биш. Эдгээр асуудлуудыг дорвитой, ахицтай, дэвшилтэй байлгахын тулд бүх оролцогч талуудын оролцоо маш чухал. Тиймээс нийт бизнесийн байгууллагууд өөрсдөө үүнд анхаарч энэ тогтолцоог хэрэгжүүлээсэй гэж хүсч байна. Ялангуяа түүчээлэн ажиллаж байгаа байгууллагуудын санал санаачилга тайлангийн ажилтай танилцаасай гэж хүсч байна. Хүний эрхийн асуудал гэдэг бол тогтвортой хөгжлийн салшгүй хэсэг байгаа.

Тиймээс тогтвортой хөгжлийн бодлого санаачилгыг дэмжиж ажиллаасай гэж хүсч байна.



Ш.Алтабагана:

Бизнесийн үйл ажиллагаа олон нийтийн өмнө нээлттэй

байдаг юуг ч нууж хаах аргагүй ийм цаг үед бид амьдарч байна. Тэр утгаараа хүний эрхийн зарчмыг тунхаглал хэлбэрээр биш бодитоор нь хэрэгжүүлэх шаардлага маш их байна. Манай салбарын хувьд уул уурхайн ложистик ялангуяа нүүрсний тээвэрлэлтийн асуудал үнэхээр хүнд байдалтай, хүний эрхийн наад захын шаардлагууд олон талаас хангагдаагүй нөхцөл байдалтай байдаг. Салбарын жишиг бол маш хэцүү. Гэхдээ энэ дунд өөр нэг бодлого, жишиг стандартыг хэрэгжүүлсэн, ийм байж болдог юм байна гэсэн кэйсийг харуулах, нөлөөллийг үзүүлэх нь маш чухал гэж боддог. Энэ утгаараа бид нилээн олон чиглэлд хүмүүсийн эрүүл аюулгүй байдалд зорчих, татвар нийгмийн даатгалыг төлөх, хүмүүсийн ажиллах, амьдрах орчин гэдгээс эхлүүлээд хүний эрхийн олон төрлийн зарчмуудыг стандарт байдлаар өдөр тутмын амьдралд нэвтрүүлж байгаа нь тодорхой хэмжээнд энэ салбарт нөлөөлж байгаа байх гэж бодож байна. Мэдээж цаашид төрийн байгууллага, ТББ, нийгмийн шахалтууд энэ аянд хэрэгтэй байна. Мөн бизнесийн байгууллагууд өөрсдөө үүнийг илүү ухамсарлах шаардлага их байна. Бид өөрсдийн хэмжээнд ТББ-аар, салбарын яамаар дамжуулж бодит бизнесийн кэйс дээр нөлөөлөхийн төлөө өөрсдийн боллоцроотой бүхнийг хийж ажиллаж байна.



С.Батбуя:

Байгууллагын удирдлага ажилтнууд болон бүх оролцогч

талууд хангалттай хэмжээний мэдээлэлтэй байх хэрэгтэй санагдсан. Хүний эрхийг хангах бизнесийг байгууллагадаа хэрэгжүүлэх гэж байгаа бол нийт ажилтнууддаа тодорхой хэмжээний мэдээллийг өгөх, авах нэн шаардлагатай. Мөн авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг өөрсдийн явуулж буй үйл ажиллагаатай уялдуулах юм бол хэрэгжүүлэх хүрээнд илүү дөхөмтэй байна. Мөн нийт ажилтнуудын оролцоог хангаж явбал энэ үйл ажиллагаа бодитой үр дүнд хүрэх болов уу гэж харагдсан. Зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээнд бусад байгууллагууд давуу талыг нь маш сайн ойлгоосой гэж хүсч байна. Хүний эрхийг хангах асуудал илүү ачаалал өгнө гэж харахаасаа илүү олон давуу талтай гэдгийг олж хараасай гэж хүсч байна.



Х.Ананд:

Компани бол тухайн хүний хоёрдох гэр нь гэсэн үг. Ажилтан

тухайн компаний үнэ цэнэ болсон байдаг. Үүнийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагууд маань ойлгож, хүний эрх, сэтгэл ханамж, өсөх ирээдүйг цогц болгож хүний эрхийн хөтөлбөрөөс аль нэгийг нь авч хэрэгжүүлж эхлэх юм бол дунд болон урт хугацаанд үр дүнгээ үзүүлнэ гэдэгт итгэдэг.

Чиглүүлэгч О.Байгаль: Олон сайхан санал санаачилга, уриалга дэвшүүлсэн та бүхэнд баярлалаа. Байгууллагын бүтэц дотроо ажилтан, албан хаагч, ханган нийлүүлэлтийн сүлжээн дотроо тайлагнах, ил тод байх тухай олон зүйлүүдийг гаргаж ирсэн та бүхэнд маш их баярлалаа. Дотоодын бизнесийн сүлжээн дэх бизнес ба хүний эрхийн асуудлуудыг та бүхэн маань түүчээлж, бусад олон бизнесийн оролцогч талууддаа таниулан сурталчилж, эдгээр зарчмуудыг хангаж ажиллахад нь бас манлайлж байгаад дахин талархал илэрхийлье. Дотоодын хамтын ажиллагаанаас гадна олон улсын бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд та бүхний оролцоо нэн чухал ба бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцын гол оролцогч тал бол бизнесийн байгууллагууд юм. Ингээд оролцогч бүх талууддаа маш их баярлалаа. Өнөөдрийн бидний хэлэлцүүлэг үүгээр өндөрлөж байна. Цаашид бид олон бизнес уулзалтуудаар туршлага, мэдлэгээ хуваалцана гэж найдаж байна.

Хурал зохион байгуулагч:

Маш сонирхолтой сэдвүүдээр ярилцсан та бүхэнд баярлалаа.

АСУУЛТ & ХАРИУЛТ

Хурал зохион байгуулагч:

Арга хэмжээний хөтөлбөрийн дагуу асуулт, хариултын хэсэг маань эхэлж байна. Цаг нилээн хоцорсон байгаа учраас цөөн хэдэн асуултуудыг та бүхнээс асууя. Хэрвээ та бүхэн асуултдаа хариулт авч амжаагүй бол чат дээр байгаа и-мэйл хаягаар холбогдож асуултын хариултыг авах боломжтой байгаа.

АСУУЛТ-1

ГХЯ-ны Оюу даргад асуулт тавьсан байна. Эко гэдэг нэрээр маш олон бүтээгдэхүүн орж ирж, сүлжээ маягаар ажиллаж, маш олон иргэдийн санхүүгийн эх үүсвэр болоод байна? Энэ бүтээгдэхүүний талаарх хараа, хяналт ямар байдаг вэ? Ард иргэдийн эрх, ашиг зөрчигдөж байгаа талаар ямар арга хэмжээ авдаг вэ? гэсэн байна.

В.Оюу: Энэ асуулт бол илүү хил гааль дээрх мэргэжлийн хяналттай холбоотой асуулт байна гэж үзэж байна.

Хурал зохион байгуулагч:

За тэгвэл бид асуултын эзэнтэй холбогдож хариултыг нь өгье.

АСУУЛТ-2

Европын Холбооны Марко Ферри дэд тэргүүнд дараагийн асуултыг тавья. GSP plus хөтөлбөрийн хүрээнд Европын Холбоонд татваргүй гарах 1700 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтыг хаанаас харж болох вэ?

Марко Ферри: _____



GSP Plus бол 6000 гаруй шалгууртай механизм, схем бөгөөд эдгээрийг хангасан тохиолдолд бараа бүтээгдэхүүн EX-руу импортлогддог. Эдгээр мэдээллүүдийг интернэтээс авч болох боловч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бараа бүтээгдэхүүнүүд, стандартууд буюу бидний нэрлэснээр "номенклатур" юм. Энэ нь маш нарийн бөгөөд техникын чанартай хүснэгтүүд байдаг. Таны асуусан асуултад хариулж чадсан гэж найдаж байна. Хэрвээ надтай холбогвол GSP PLUS журамд багтсан бүтээгдэхүүний жагсаалт бүхий холбоосыг та бүхэнд явуулахдаа баяртай байх болно.

АСУУЛТ-3

Хүний эрхийн хуульч Мойлтмаагаас асууя. Малчдад, амьжиргаага алдсан хүмүүст гарсан хохирлыг барагдуулах гэсэн концепц бол маш хоцрогдсон бодлого болоод байна. Тэдний амьдралаа баталгаажуулах, цаашид орлого олох зэргийг тооцдоггүй. Энэ талаар танай хөтөлбөр юу хийх вэ гэсэн асуулт байна.

С.Мойлтмаа: _____



Шууд хариулахад боломжгүй нилээн өргөн хүрээний асуулт байна. Мэдээж бизнес ба хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу малчин иргэдийн бүлгийг анхааралдаа авах болно. Шаардлагатай бүх хэлэлцүүлгийг малчин иргэд, орон нутгийн удирдлагуудтай нь хийнэ. Тиймээс энэ хүмүүсийн ямар эрх, хаана зөрчигдөж байна? Ялангуяа ямар бизнесийн процесс дээр зөрчигдөж байна? яаж эрхийг нь эдлүүлэх таатай орчин бүрдүүлж болох вэ? гэдэг асуудал бол зөвхөн бид нар сууж байгаад хэлэх боломжгүй ийм том хүрээний асуудал. Та бүхэн малчин иргэдтэй холбоотой, хүний эрхийн зөрчилтэй холбоотой мэдээллүүд, тоо баримт, судалгаа байвал хамтран ажиллах бүрэн боломжтой. Хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулж яг энэ асуудлуудыг хамтран гаргаж тавих боломжтой байгаа гэж хэлмээр байна.

АСУУЛТ-4

Дараагийн асуултыг Хүний эрхийн үндэсний комисст хандуулъя. Монголын бичил уурхайн төлөөлөл Дээвэр холбооноос ирүүлсэн асуулт байна. Нийт орон нутгийн ажиллах хүчний 20 хувийг бүрдүүлдэг энэ салбарыг албажуулах, энэ салбарт хүний эрхийг хамгаалах талаар ажиллаж байгаа иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих хэрэгцээ шаардлага байна. Энэ тал дээр хэрхэн ажиллах вэ?

Ө.Ундрах:



Комиссын хувьд бичил уурхайн асуудал дээр 2012 оноос 2019 он хүртэл тогтвортойгоор ажилласан. 2012 онд бид уул уурхайн бизнес ба хүний эрх олон улсын чуулга уулзалтыг хийх үедээ энэ бичил уурхайн асуудлыг сөхөж, тухайлан оруулсан. Тухайн үед бичил уурхайтай холбоотой зөвлөмжүүдийг шийдвэр гаргагч, бодлого тодорхойлогч нарт өгч байсан. Зөвлөмж өгөөд зогсоогүй

2012 оноос хойших хугацаанд жил болгон Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран бичил уурхай эрхлэгчдийн эрхийн асуудал, бичил уурхайн нөлөөлөлд өртөж байгаа хүмүүс, нутгийн зон олны эрхийн асуудал дээр судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалт хийж, бичил уурхайчид болон тэдгээрийн эрхийг хэрэгжүүлэх ёстой албан хаагчид, холбогдох бусад хүмүүсийг оролцуулсан сургалтын үйл ажиллагаа явуулсан.

Бичил уурхайн бизнес албан бус байгаа боловч албажих шаардлагатай, ялангуяа нөхөрлөлийн холбоонд оролцуулах чиглэлээр холбогдох байгууллагууд болон бичил уурхайн холбоотой хамтран ажилласан. Үүний үр дүнд 2019 онд тодорхой хэмжээнд асуудлууд шийдэгдсэн. Ер нь цаашид бичил уурхайн талаар гарсан санаачилгыг дэмжиж ажиллах бүрэн боломжтой. Энэ үйл ажиллагаа эцсийн үр дүнгээ гаргаж, албажиж дуусаагүй байна. Хэдийгээр дүрэм журам, хууль тогтоомжид тодорхой хэмжээгээр өөрчлөлт орсон боловч зөвхөн бичил уурхайд хамаарч байгаагаас гадна нинжа гэж гарч ирж, албан ёсоор аж ахуй эрхлэгчдэд сөргөөр нөлөөлөх, зөрчилдөх асуудал тодорхой хэмжээгээр гардаг учраас энэ асуудлууд дээр байгаль орчин хүний эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгч Жон Ноксийг ирэх үед Заамар суманд хамтран ажиллаж, газар дээр нь очиж танилцах зэргээр энэ асуудлыг сөхөж байсан.

Цаашид бичил уурхайн чиглэлээр ялангуяа хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах талаар судалгаа хийх, дүн шинжилгээ хийх, гарч байгаа, гарч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа явуулах талын ажлыг хийх боломж бий.

АСУУЛТ-5

Сүүлийн асуултыг МҮХАҮТ-аас асууя. Бизнес ба хүний эрхийн зарчмуудыг ерөнхийдөө компанийн удирдлагын түвшинд ойлгуулах, таниулах талаар ТББ-уудын гаргаж байгаа саналуудыг хэрхэн яаж дэмжиж ажиллах вэ?

О.Байгаль:



Бизнес ба хүний эрхийн үндэсний үйл ажиллагаа хөтөлбөр боловсруулах ажил дөнгөж эхэлж байна. Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим бол ажлын хэсэг дотор ороод, гүйцэтгэх хороонд бас төлөөллөө оролцуулж ажиллаж байна. Танхим нээлттэйгээр хамтран ажиллахад бэлэн байна.

Хурал зохион байгуулагч:

За ингээд манай өнөөдрийн арга хэмжээ хаалтын хэсэг рүүгээ орж байна. Өнөөдрийн арга хэмжээний хаалтыг хийнэ үү? хэмээн нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн орлогч суурин төлөөлөгч Нашида Саттар таныг урьж байна.

Хаалтын үг

Нашида Саттар:



Та бүхэнд маш их баярлалаа. Гурван цагийн турш маш баялаг мэдээллийг бид хуваалцлаа гэж миний хувьд үзэж байна.

Энд нэг зүйлийг онцлоход бидний өнөөдрийн фэйсбүүк болон бусад сошиал платформуор хүргэсэн шууд дамжуулалтыг 200 гаруй хүн нэгдэн үзэж, санал сонирхлоо бидэнд илэрхийллээ. Энэ нь энэхүү төсөл маань Монголд цаг үеэ олсон, зайлшгүй шаардлагатай төсөл гэдгийг харуулж байна. Энэхүү санаачилгыг эхлүүлснийг ийнхүү дэмжин хүлээж авч байгаад би маш их баяртай байна. Төгсгөлд нь хэлэхэд өнөөдрийн үйл ажиллагаанд оролцсон ГХЯ, ЕХ, Азийн Бизнес ба Хүний Эрх хөтөлбөр, ХЭҮК, мөн дотоодын болон олон улсын жишээ, олон төрлийн стандартын талаар мэдээлэл хүргэсэн төрөл бүрийн салбарын олон панелистууд, дотоодын болон олон улсын компаний төлөөлөлд гүнээ талархал илэрхийлье. Түүнчлэн Монголдоо үйл ажиллагаа явуулж байгаа дотоодын компаниуд хүний эрхтэй холбоотой гомдол саналыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар сонсоход үнэхээр таатай байлаа. Энэ үйл ажиллагаанд оролцсон модераторууд болон панелистуудаа дахин талархал илэрхийлээд өнөөдрийн ажиллагаа хаасныг мэдэгдэж байна. Энэ хэлэлцүүлэг үнэхээр амжилттай боллоо.

Та бүхэнд маш их баярлалаа.

